



**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**

ШУТИС-ИЙН ОЮУТНЫ КЛУБУУДИЙН 2021-2022 ОНЫ НАМРЫН УЛИРЛЫН ТАЙЛАН



ШУТИС-ИЙН ОЮУТНЫ КЛУБУҮҮДИЙН 2021-2022 ОНЫ НАМРЫН УЛИРЛЫН ТАЙЛАН

Улаанбаатар
2021

Тайлан эмхтгэн хэвлүүлсэн:

ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Цогзолмаа

Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн ахлагч:

БАС-ийн Архитектурын V курсийн оюутан Х.Оюунтүлхүүр

Хэвлэлийн хуудас: 210*297

ШУТИС-ийн хэвлэлийн газарт хэвлэв.

ӨМНӨХ ҮГ

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын, урлагийн клубүүдийн үйл ажиллагааг их сургуулийн хувьд бодлогоор дэмжин хөгжүүлэх нь үр дүнтэй байдаг. Клубийн гишүүн оюутнууд хүсэл, сонирхлоороо нэгдэн нэг баг хамт олон болж, хамтдаа хөгжиж, их сургуулийн оюутанд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулж байгаа нь клубүүдийн тайланд тусгагдсан үйл ажиллагаанаас харагдаж байна.

Клубүүд нь үйл ажиллагааны тайлангаа улирал бүр тайлагнан дүгнүүлж багш, удирдлагуудын санал, шүүмжийг сонсон үйл ажиллагаандаа хяналт тавьж сайжруулан ажилладаг.

2021-2022 оны намрын улиралд клубүүдийн тайлан хэлэлцэх хуралд нийт 24 клуб тайлангаа хэлэлцүүлсэн байна. Клубүүдийн тайланг эмхэтгэн 3 дахь удаагаа хэвлүүлэн нийтийн хүртээл болгож байна. Тайланг улирал бүр ШУТИС-ийн вебд тавьж оюутнууддаа цахимаар хүргэж байгаа болно.

2021-2022 оны намрын улирлын тайлан хэлэлцэх комисст дараах багш нар ажиллав. Үүнд

Мэргэжлийн клубүүдийн тайлангийн хуралд

1. Д.Цогзолмаа ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D)
2. В.Алимаа ГУУС-ийн Газрын тос, өрөмдлөгийн салбарын дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор
3. М.Цас-Оргилмаа БАС-ийн Инженерийн байгууламжийн салбарын ахлах багш, доктор (Ph.D)

Сайн дурын клубүүдийн тайлангийн хуралд

1. Н.Санчирбаатар ОСҮА-ны дарга
2. Б.Дондогжамц МехТС-ийн Мехатроникийн салбарын багш, доктор (Ph.D)
3. Н.Оюунцэцэг ГХС-ийн Англи хэл судлалын тэнхимийн ахлах багш нар ажилласан


Цар тахалтай энэхүү цаг үед хамт олноо манлайлсан МХТС-ийн “Sys&CoTech” клубийг Академич Х.Энхжаргалын нэрэмжит шагналаар шагнуулахаар шалгаруулсан бол. Мэргэжлийн шилдэг клубээр ҮТС-ийн “WIZZ” клуб, шилдэг клубийн ахлагчаар ГХС-ийн “Звёздочка” клубийн ахлагч М.Самбууням, Мэргэжлийн клубийн шилдэг гишүүнээр ХШУС-ийн “Залуу Экологи” клубийн гишүүнийг тодруулан шагнав. Сайн дурын клубүүдээс шилдэг клубээр “Соёмбо” клуб, Шилдэг клубийн ахлагчаар “Empowerment” клубийн ахлагч Х.Оюунтүлхүүр, клубийн шилдэг гишүүнээр “Patiaг клубийн гишүүнийг тус тус шагнаан урамшуулсан.

Оюутнуудынхаа хийж, бүтээж буй үйл ажиллагааны үр дүнг эмхтгэн та бүхэндээ толилуулж байна.


КЛУБУУДИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨЛИЙН АХЛАГЧ Х.ОЮУНТҮЛХҮҮРИЙН АЖЛЫН ТАЙЛАН

ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн, урлагийн клубүүд нь оюутны санал санаачлагад тулгуурлан үүсгэн байгуулдаг бөгөөд ОСҮА-аас хариуцан удирдлагаар ханган хамтран ажилладаг. ШУТИС-ийн оюутан бүрийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, багийн ажиллагааг хөгжүүлэх, харилцан суралцах, оюутан оюутандаа нөлөөлөхөд клуб, клубийн систем ихээхэн үр нөлөөтэй юм.

Клубийн системийг ерөнхийлөн авч үзвэл



Одоогийн байдлаар ШУТИС-д нийт 55 клуб бүртгэлтэй байгаагаас 30 орчим клуб үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж 1132 оюутнуудыг хамран ажиллаж байна. Үүнээс мэргэжлийн клубүүд 418 гишүүн буюу 36% -ийг, сайн дурын клубүүд 639 гишүүн буюу 58%-ийг, харин урлагийн клубүүдийн хувьд 75 гишүүн буюу 6% -ийг эзэлж байна. Мөн графикаас ажиглахад II дамжааны оюутнууд клуб-д илүү идэвхтэй хамрагдаж байгаа бол төгсөх дамжааны оюутнуудын хувьд хамгийн бага оролцоотой байна. Нийт клубүүдийн хувьд гишүүд гэдэг амин сүнс нь байдаг бөгөөд клубд шинээр орж ирж буй I дамжааны оюутнуудад чиглэн үйл ажиллагаа явуулахыг зорьж байна.



Клубүүдийн ахлагчдын мэдээлэл

№	Клубийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ахлагчийн нэр	Утас
1.	Whizz	График дизайн	Г.Жавхлан	80510720
2.	Sys&CoTech	Мэдээллийн технологи	Б.Номин-Эрдэнэ	94351314
3.	Finde	Үйлдвэрлэлийн дизайн	Дашбалмаа	86679005
4.	Inspiration	Хувцас загвар	Л.Гүнжинлхам	80276812
5.	Энергетик	Дулааны инженерийн мэргэжлээр сурдаг оюутнуудад мэдлэг мэдээлэл олгох	Болдсүх	99827541
6.	Залуу экологич	“Хүрээлэн байгаа орчин болон экологийн салбар ШУ” чиглэлээр суралцаж буй оюутан залуусын мэргэжлийн чадварыг дээшлүүлэх	Б.Нямдарь	89761319
7.	СЭХ	Сэргээгдэх эрчим хүч	Ө.Манал	86666460
8.	Цахиур	Програмчлал ба алгоритм тоцоолон бодох	Тэмүүжин	91115121
9.	Звёздочка		М.Самбууням	96700009
10.	MUST Comedy		Г.Золжаргал	88828420
11.	Empowerment	Илтгэх урлаг, мэтгэлцээн	Х.Оюунтүлхүүр	94212142
12.	AIIESEC	Залуусын манлайллыг хөгжүүлэх, соёл солилцооны сайн дурын хөтөлбөр явуулах	Б.Эрдэнэсайхан	88691077
13.	Хятад хэл	Хэл	О.Сумьяабазар	86161855
14.	Patiar	Гэрэл зураг	А.Учралтням	80189588
15.	Соёмбо	Хэв журам сахиулах	Бекболат	85209929
16.	Залуучуудын улаан загалмай		С.Мичидмаа	80274005
17.	БТОК		О.Сансармаа	94181495
18.	Мэргэн шагайн харваа		С.Бат-Эрдэнэ	85455655
19.	Морин хуур		Э.Мэнд-Амар	89145498
20.	Хос уянга	Цэнгээнт бүжиг	Б.Лхагвабат	89304300
21.	Хөтлөгч		Г.Батцэцэг	80307063
22.	Дуулаач		Т.Тулгабат	85920914
23.	Чөлөөт бүжиг	Чөлөөт бүжиг	Цолмон-Эрдэнэ	99213507

Клуб тус бүр өөр өөрсдийн гэсэн онцлогтой байдаг бөгөөд үүнээсээ хамаарч гишүүн элсүүлж авах болон ажлын төлөвлөгөө нь хавар, намрын улиралдаа өөр өөр байдаг. Аливаа нэг клубийн ахлагчын чадвараас тухайн клубийн үйл ажиллагаа ихээхэн хамааралтай төдийгүй өөрийн хичээл номны хажуугаар гишүүдээ идэвхжүүлэх, өдөр тутмын клубийн дотоод үйл ажиллагаагаа зохион байгуулах, төлөвлөгөө, төсөв, тайлан бичих, КНЗ-өөс болон ШУТИС-ээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд гишүүдээ оролцуулах, сайн үйлсийн аян гээд л чамгүй ачааг нуруун дээрээ үүрч явдаг. Ахлагч бүрийн энэхүү нөр их хичээл зүтгэлийн үндсэн дээр ШУТИС-ийн клубүүдийн нэгдсэн зөвлөл бүрэлдэн тогтнож байдаг.

Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн хувьд 1 хүн даргаар томилогдохоос илүүтэйгээр клубээрээ нэгдэж клубүүдийн нэгдсэн зөвлөлийн удирдах зөвлөлөөр ажиллах болсон энэхүү үйл ажиллагаа 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар “Empowerment” клуб удирдах зөвлөлөөр 2021-2022 оны намрын улирлаас эхлүүлэн намрын семистр ажилсан.

Ингээд 2021 -2022 оны намрын улирлын КНЗ-ээс клубүүдийн дунд зохион байгуулсан нэгдсэн үйл ажиллагааг танилцуулъя. Үүнд:

Танд тусалъя аян

Энэхүү үйл ажиллагааны хувьд шинээр оюутан болж орж ирж буй I дамжааны оюутнуудад клубүүд сайн дураараа тусламж үзүүлэх, заавар зөвлөгөө өгч чиглүүлэх зорилготой.

Шинээр оюутан болоход олон олон асуудал, эргэлзээ, өрөө байршил, төлбөр, хичээл сонголт, зөвлөх багшаа олох гээд л наад захын асууж лавламаар зүйлс цөөнгүй байдаг тэр бүгдэд тус дэм болж энэ улиралд 5 клубийн 31 оюутан 2021.09.13-17 ны өдрүүдэд нийт 400 орчим оюутнуудад мэдээлэл өгсөн.

№	Клубийн нэрс	Хичээлийн байр	Огноо
1	Empowerment	I, II, номын сан	2021.09.13
2	БТОК	I, II	2021.09.14
3	Соёмбо	I, II, номын сан	2021.09.15
4	Залуу экологич	I, II	2021.09.16
5	Finde	I, II, IV	2021.09.17



Клубийн нэгдсэн зөвлөлийн хурал

2021-2022 оны намрын улирлын клубүүдийн нэгдсэн зөвлөлийн хурлыг 2021.10.13 нд зохион байгуулсан ба оюутан залуусын сурч хөгжих боломжид цаашлаад ямар үйл ажиллагаа зохион байгуулах, хэрхэн гүйцэтгэх талаар санал бодлоо хуваалцсан төдийгүй цахим, танхимын үйл ажиллагааг хослуулан ажиллахад өөрсдийн байр сууриа илэрхийлэн амжилттай зохион байгуулагдсан.



Клубүүдийн ахлагч нарыг чадваржуулах “Баг хамт олныг удирдах багийн ажиллагааг хөгжүүлэх” сургалт

2021 оны 11 сарын 11 ны өдөр “Ахлагч нарыг чадваржуулах сургалт”-ийг зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 23 клубийн ахлагч нар оролцсон. Уг сургалтад судлаач зөвлөх багш А.Энхцэцэг “Баг хамт олныг удирдах багийн ажиллагааг хөгжүүлэх” үндсэн ойлголтын дагуу оюутан залуус баг хамт олныг бүрдүүлэхээс гадна удирдан чиглүүлэн оролцох нь цаашлаад ажлын байранд ч гэсэн чухал чадвар төдийгүй бусадтай харилцах, ойлголцох, зохион байгуулах яадварыг тайлбарласан төдийгүй

- Шийдвэр гаргалтын мөн чанар
- Шийдвэрийн төрөл, ангилал, түвшин
- Ажлын бүтээмж
- Стратегийн менежмент
- Манлайлан удирдахуй
- Идэвхжүүлэх арга
- Асуудал шийдвэрлэх чадвар

Оновчтой шийдвэр гаргалтын арга зүй эхлэлээс энэхүү 4 жилийн хугацаанд бид юуг хэзээ нь сурч авах ёстой байдаг хийгээд өөрт ноогдох орон зайг эзэгнэж, хувь хүнээс бие хүний төлөвшил, үргэлжлээд төлөвшсөн хүн бусдыгаа манлайлах буюу нөлөөлөх ур чадварт суралцах гэх мэт багаас нь эхлээд ихрүү нь чиглэсэн маш олон үнэтэй мэдээллийг өгч клубийн ахлагч нарт зөвлөн тайлбарласан үр өгөөжтэй сургалт зохион байгуулагдсан.



Сайн үйлсийн аян /SaveMunkhuu/

ШУТИС-ын Цахилгаан электронникийн инженер мэргэжлээр суралцаж байгаа төгсөх курсийн оюутан Д.Эрдэнэманх 21 настай нарийн, шулуун гэдэсний хорт хавдартай, элгэндээ үсэрхийлсэн гэсэн харамсалтай оношоор эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон. Мөн химийн эмчилгээнд орсон ч цусны архаг дутмагшилтай, ялтас эсийн хэмжээ нь хэвийн хэмжээнээс өндөр байгаа тул дахин химийн эмчилгээнд орох боломжгүй болсон. Турк улсын Acibadem Altunizade Hospital эмнэлгээс эмчлэгдэх боломжтой яаралтай эмчилгээнд хамрагдах шаардлагатай гэсэн тул ШУТИС-ийн Клубүүдийн нэгдсэн зөвлөлөөс энэхүү аянд өөрсдийн явуулдаг үйл ажиллагаа, зохион байгуулалтаар дэмжин тусалсан.



Клубүүдийн нэгдсэн тайлан

2021.12.10-ний өдөр КНЗ-ийн мэргэжлийн болон сайн дурын нийт 24 клубүүдийг хамарсан клубүүдийн нэгдсэн тайлан болсон. Тайлан хэлэлцүүлсэн клубүүдээс шилдэг клуб, шилдэг ахлагч, шилдэг гишүүдийг шалгаруулан үйл ажиллагаа амжилттай зохион байгуулсан.



2021-2022 оны хичээлийн жилд идэвх санаачлагатай байж, үйлс бүтээлээрээ бусдыгаа манлайлсан шилдэг клуб болон шилдэг ахлагч нарыг дурьдвал:

Шилдэг мэргэжлийн клуб: **Sys&CoTech**

Шилдэг мэргэжлийн клубийн ахлагч: М.Самбууням/ Звёздочка клуб /

Шилдэг сайн дурын клуб : **Соёмбо**

Шилдэг сайн дурын клубийн ахлагч: **Х.Оюунтүлхүүр /Empowerment клуб/** нар тодорч ШУТИС-ийн клубүүдийн нэгдсэн зөвлөлийн түүхийн хуудаснаа өөрсдийн амжилтаа мөнхөллөө.



ШУТИС-ийн клубийн эрх, үүрэг

ШУТИС-ийн оюутнуудыг хөгжүүлэн төлөвшүүлэх, хамтран ажиллах, харилцан суралцахад чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг клубийн системээр оюутанд хүргэх буюу оюутан оюутандаа нөлөөлөх нь ихээхэн үр дүнтэй үйл ажиллагаа юм.

- ШУТИС-ийн оюутны санаачлагаар бий болсон клубүүдийн үйл ажиллагааг ОСҮА хариуцсан удирдлагаар ханган хамтран ажиллана.
- ШУТИС-ийн оюутны сайн дурын болон мэргэжлийн клуб нь оюутны санал санаачлагад тулгуурлан үүсгэн байгуулсан байна. Клуб зөвлөх багштай байж болно.
- Клуб нь өөрийн танилцуулгыг ШУТИС-ийн вебд байрлуулсан байна.
- Клубүүд ажлын тайлангаа улирал бүрийн сүүлийн долоо хоногийн баасан гарагт хэлэлцүүлнэ.
- Тайланг үндэслэн дараа улирлын ажлын төлөвлөгөөнд шаардагдах төсвийг холбогдох нэгжүүд, бүрэлдэхүүн сургуулиас авах боломжтой.
- Клубийн ажлын үр дүнг харгалзан клубийн ахлагч, идэвхтэй гишүүд, оюутан багш нарт кредитийн урамшуулал олгох журмын дагуу урамшуулна.
- Шинээр байгуулагдсан клубийн хагас жилийн ажлын үр дүнг харгалзан ОСҮА-наас батламж олгоно.
- Клубийн гишүүнчлэлийг нээлттэй хэлбэрээр авна.

КЛУБИЙН ЭРХ:

- Үйл ажиллагааг клуб дангаараа болон бусад клубүүдтэй хамтран зохион байгуулах
- Клуб өөрийн үйл ажиллагааны чиглэлээр их сургуулийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, санал дэвшүүлэх
- Клуб нь их сургуулийн аль нэг анги эзэмших болон хамтран эзэмших
- Клуб өөрийн үйл ажиллагааны хүрээнд их, дээд сургууль болон улс, олон улсын хэмжээнд тэмцээн уралдаан зохион байгуулах
- Клуб өөрийн үйл ажиллагаанд зөвлөгөө авах мэргэжлийн зөвлөх багш болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах
- Клуб төсөл хөтөлбөрт хамрагдах, Эрдэм шинжилгээний хурал, бүтээлийн үзэсгэлэн бусад уралдаан тэмцээнд оролцох

КЛУБУУДИЙН ҮҮРЭГ:

- Клуб нь гишүүдээ ШУТИС-ийн болон Клубүүдийн нэгдсэн зөвлөлөөс зохион байгуулж буй нэгдсэн арга хэмжээ, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах
- Тайлангаа цаг хугацаандаа хэлэлцүүлэн дүгнүүлэх
- ШУТИС болон бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд оюутанд чиглэсэн шинэлэг, сайн дурын 1-2 ажлыг санаачлан хэрэгжүүлэх

ШУТИС-ИЙН МЭРГЭЖЛИЙН КЛУБУУДИЙН ТАЙЛАН

Sys&CoTech клубийн тайлан


“Sys&CoTech” клуб нь 2009 оноос хойш өдгөө 12 дэх жилдээ мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа оюутны сайн дурын нэгдэл юм. Одоогоор I-IV дүгээр курсийн нийт 28 идэвхтэн гишүүн, 80 гаруй зөвлөх гишүүнтэй. Энэ семестер корона вирусийн дэгдэлттэй холбогдуулан 3-р долоо хоногоос эхлэн нийт 13 долоо хоног үйл ажиллагаагаа идэвхтэй явуулсан байна.

Энэ хугацаанд дараах үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Үүнд:


1. Шинэ гишүүний элсэлт
2. Програмчлалын олимпиад
3. “Tea time” сайн үйлсийн үйл ажиллагаа
4. Сургалт
 - 4.1. Гадаад сургалт
 - 4.2. Дотоод сургалт
 - 4.2.1. Арилжааны техник шинжилгээний сургалт
 - 4.2.2. Жаваскрипт сургалт
5. Дотоод үйл ажиллагаа
 - 5.1. Цэвэрлэгээ
 - 5.2. Багуудын үйл ажиллагаа

1. Шинэ гишүүний элсэлт

Манай клуб нь хичээлийн улирал бүр шинэ гишүүний элсэлт авдаг. Энэ семестерийн шинэ гишүүний элсэлт 9 сарын 21-ээс 9 сарын 24-ний хооронд 3 үе шаттай явагдсан. Эхний үе шатанд МТХС-ийн 1-3р курсийн оюутнуудаас анкет болон бүтээлч ажил авч шалгаруулсан ба нийт 23 оюутанаас 14 оюутан тэнцэж ярилцлагын шатанд орсон. Улмаар идэвх санаачлага, нийгмийн идэвхтэй гэж үзсэн 8 оюутан шалгарч идэвхтэн гишүүнээр элссэн.



Зураг 1.1. Хоёрдугаар үе шат /Ярилцдага/




Зураг 1.2. Хоёрдугаар шатны снэл хураалт /Ярилцлага/

2. Програмчлалын олимпиад


ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн мэдээллийн технологийн тэнхимийн дэргэдэх “Sys&CoTech” клубээс уламжлал болгон зохион байгуулдаг “Програмчлалын олимпиад-2021” тэмцээн нь 2021 оны намрын семестерт МХТС-ийн I-III курсийн оюутнуудын дунд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний бүртгэлийг 2021 оны 11-р сарын 03-ны 10:00 цагаас 11-р сарын 10-ны 12:00 цагийн хооронд <https://syscotech.club/> буюу клубын веб хуудсаар дамжуулан хүлээн авсан. Тэмцээнд бүртгүүлсэн нийт 62 оюутнаас I курсийн 31 оюутан, II курсийн 24 оюутан III курсийн 7 оюутан оролцсон нь өмнөх жилүүдтэй харьцуулахад оролцогчдын тоо өссөн үзүүлэлттэй байна. 11 сарын 11-ны өдөр I-р үе шат буюу Онлайн олимпиад нь хөтөлбөрийн дагуу нээлт 16:30- 17:00 Google meet ашиглан явагдсан ба 17:00 Олимпиадын бодолтын хугацаа эхлэсэн 1р шат HackerRank”-ын бодлогын уралдаан нийт оролцогчдын дунд эхэлсэн. Нийт 3 түвшин бүхий 6 бодлого, тус бүр 100 оноо авах журмаар явагдсан. Олимпиадын бодлогыг улсын мэдээлэл зүйн олимпиадын тэргүүн байр, МУИС-н програм хангамжийн төгсөгч А. Батжаргал бэлтгэн, бодолтыг хянаж ажилласан. Тэмцээн 3 цагийн турш үргэлжилсэн бөгөөд 20:30 цагт бодолтын хугацаа дуусаж, тэмцээн хаагдсан. 20:30-21:30 цагуудын хооронд эхний шатанд тэнцсэн оролцогчдыг шалгаруулж, зарласан үүнийг клубийн албан ёсны facebook page-ээр дамжуулан хүргэсэн болно. 11 сарын 13-ны өдөр 2-р үе буюу Танхимийн олимпиад ШУТИС-МХТС дээр зохион байгуулагдсан. 11:20-с оролцогчдын бүртгэл баталгаажуулалт явагдсан ба олимпиадын дэг, хөтөлбөрийг танилцууласанаар 12:00 цагт 2-р шатны олимпиад 320, 324 тоотуудад эхлэсэн. Тэмцээн 3 цагийн турш үргэлжилсэн бөгөөд 15:00 цагт өндөрлөж нийт оролцогчдод үдийн цай тараасан. Хаалтын арга хэмжээ тэмцээн дуусмагц ШУТИС-МХТС 401 тоот ангид явагдсан бөгөөд МХТС-н мэдээллийн технологийн тэнхимийн эрхлэгч А. Алтангэрэл, ерөнхий ивээн тэтгэгч “Наашаа тек ХХК”-н захирал Чинбат болоод ахлах хөгжүүлэгч А. Хос-Эрдэнэ болон “Систем центр” ХХК-н захирал нар нийт оролцогчидод хандан үг хэлсэн. Үүний дараа оролцогчдын бодолтод анализ хийж , эхний таван байранд орсон оролцогчдын бодолтыг тайлбарлуулан ялагчдыг шалгаруулсан. Мөн нийт оролцогчдодоо бодлогуудаа тайлбарлаж хэрхэн бодох байсан талаар ярилцаж, шагнал гардуулснаар 16:00 цагт тэмцээн албан ёсоор өндөрлөсөн. Тэмцээний тэргүүн байранд хиймэл оюун ухааны ангийн II курсийн оюутан О. Итгэл , дэд байранд компьютерын ухааны ангийн III курсийн оюутан Д. Батсүх , гутгаар байранд программ хангамжийн II курсийн оюутан Л.Гүндалай тус тус шалгарсан. Шагнал гардуулах үйл ажиллагаа дууссаны дараа шагналын мөнгийг оролцогч бүрийн дансаар, өргөмжлөлийг хувийн мэйлээр илгээсэн.



Зураг 2.1. Олимпиадын пост



Зураг 2.2. Олимпиадын зар



Зураг 2.3. Лидер боард

Contest Challenges

add challenges to your contest by selecting challenges from our library or create and add your own challenges here. To reorder your challenges, simply select the challenge and then drag and drop to the desired location.

Add Challenge

No.	Name	Max Score	Binary	Editorial
1.	3+5=8	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2.	Squid game	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3.	Dish Wash	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4.	Point	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5.	Substring	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6.	Аль нь 8?	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7.	Ийн амархан байсан юу?	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8.	Юу болонд байсан бэ?	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9.	Жоохон нундэрхын ямар нэг?	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10.	Сомебак 777	100	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Зураг 2.4. HackerRank contest



Зураг 2.5. Олимпиадын хаалт



Зураг 2.6. Шагналт байранд шалгарсан оюутнууд болон ивээн тэтгэгч байгууллагын төлөөллүүд



Зураг 2.6. Шагналт байранд шалгарсан оюутнууд болон ивээн тэтгэгч байгууллагын төлөөллүүд



Зураг 2.6. Шагнал гардуулалт



Зураг 2.6. Олимпиадын үйл явц



Зураг 2.7. Олимпиадын үйл явц



Зураг 2.6. Бүртгэлийн үйл явц

3. “Tea time” сайн үйлсийн үйл ажиллагаа

Залуучууд бид өвлийн хүйтэнг үл ажиран гадаа ажиллаж буй хүмүүст жоохон ч болов сэтгэлийн дэм болох үүднээс “Tea Time” аянг зохион байгуулсан. Уг аянаар замын цагдаагын алба хаагчид, “ТҮК”-н ажилчид гэх мэт хүйтэнд ажилладаг хүмүүсд цай, чацаргана, аарц гэх мэт халуун зүйлсээр тусалсан.



Зураг 3.1. "Tea time" үйл явц



Зураг 3.2. "Tea time" үйл явц



Зураг 3.3. "Tea time" үйл явц

4. Сургалт

Сургалт нь клубийн уламжлал болгон зохион байгуулдаг үндсэн үйл ажиллагаа ба ШУТИС-МХТС-н оюутнуудын хичээлийн идэвхи оролцоог нэмэгдүүлэх, чадавхижуулах зорилготой. Ихэвчлэн суурь хичээл буюу Програмчлалын үндэс/С хэл/, Объект хандлагат програмчлал /Java хэл/ гэсэн хичээлүүдийн сургалт явуулдаг. Мөн дотооддоо буюу идэвхтэн гишүүдийг чадавхижуулах зорилготой сургалтуудыг явуулдаг. Энэ семестер корона вирусын халдварын нөхцөл байдлаас үүдэн олон хүн цуглуулах боломжгүй тул Програмчлалын үндэс /С хэл/, Объект хандлагат програмчлал /Java хэл/ болон “Photoshop”-н хичээлүүдийг цуврал видео болгон клубын “Youtube” сувагт оруулан хүмүүст хүргэсэн. Энэ нь танхимаар орохоос илүү ШУТИС-МХТС-н оюутнууд болон мэдээллийн технологийн чиглэлээр сонирхон судалдаг, суралцдаг хүмүүст хүрсэн.

4.1. Гадаад сургалт

Гадаад сургалт нь ШУТИС-МХТС-н оюутнуудруу чиглэгдэн явагддаг.

“Sys&CoTech” клубийн 2021-2022 оны намрын улирлын “Програмчлалын үндэс”, “Объект хандлагат програмчлал” хичээлийн тайлан.

1. Зорилго

Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуулийн оюутнуудад “Програмчлалын үндэс” болон “Объект хандлагат программчлал” хичээлийг анхан шатнаас гүнзгий шат хүртэл заах, нэмэлт давтлага олгох, хоцрогдол арилгах, багшаас асууж чадахгүй зүйлээ чөлөөтэй асууж, хариулт олж авахад нь туслах зорилготой.

2. Зорилт

- Оюутнуудын хичээлийн хоцрогдол арилгах
- Анхан шатнаас нь эхлэн сургах
- Сорил, шалгалтад бэлтгэх
- Олимпиад, тэмцээний талаар нэмэлт мэдлэг олгох, бэлтгэх

3. Хичээлийн талаар ерөнхий мэдээлэл

Мэдээлэл, Холбооны Технологийн Сургуульд заагддаг CS101 кодтой “Програмчлалын үндэс”, CS202 кодтой “Объект хандлагат програмчлал” хичээлүүдийн агуулгын хүрээнд програмчлалын “С” болон “Жава” хэлний хичээлийг заасан.

Багшлагч оюутан:

- Мэдээллийн технологийн 4-р курсийн оюутан Б.Номин-Эрдэнэ(В180930039)
- Програм хангамжийн 3-р курсийн оюутан Б.Ариунсанаа (В190910009) нар хамтран заасан.

Хичээл заасан өдөр:

- Долоо хоног бүрийн лхагва гаригт “Програмчлалын үндэс”,
- Долоо хоног бүрийн баасан гаригт “Объект хандлагат програмчлал”

Хичээл заасан байдал:

- Хичээлийг клубийн албан ёсны Youtube хуудсанд байрлуулж, сургуулийн болон клубийн facebook хуудсаар оюутнуудад зар түгээж байсан. Мөн

клубийн discord server ашиглан оюутнуудын санал бодол асуух, асуултанд хариулах зэргээр ажилласан.

4. Хичээлийн төлөвлөгөө

“Програмчлалын үндэс” хичээлийн төлөвлөгөөг Хүснэгт 1-т , “Объект хандлагат програмчлал” хичээлийн төлөвлөгөөг Хүснэгт 2-т үзүүлсэн. Төлөвлөгөөг танхимаар орох нөхцөл байдалд тохируулан гаргасан бөгөөд цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар орох болсон ч төлөвлөгөөний дагуу хичээлүүдийг заасан.

Хүснэгт 1. Програмчлалын үндэс хичээлийн төлөвлөгөө

Долоо хоног	Сэдэв	Агуулга
7	IF statement	IF, ELSE, ELSEIF тухай үндсэн ойлголт Жишээ бодлогууд, Үндсэн хэрэглээ
8	Function	Функц, түүний хэрэглээ, хэрхэн ашиглах
9	Давталт	3 төрлийн давталтын талаар үндсэн ойлголт - FOR - WHILE - DO WHILE
10	Массив	Массивын тухай үндсэн ойлголт Массивыг зарлах, үүсгэх, ашиглаж сурах
11	Заагч	Заагч, түүний чухал ойлголтууд, хэрхэн хэрэглэх
12	Tic Tac Toe #1	C хэл дээрх үзсэн ойлголтуудаа ашиглан жижиг тоглоом эхнээс нь дуустал хийж үзэх
13	Tic Tac Toe #2	
14	Tic Tac Toe #3	
15	Хөшигний цаана #1	C хэл дээрх код доод түвшиндээ хэрхэн ажилладаг вэ? Бидний нүднээс далд ямар процесс болдог тухай
16	Хөшигний цаана #2	

Хүснэгт 2. Объект хандлагат програмчлал хичээлийн төлөвлөгөө

Долоо хоног	Сэдэв	Агуулга
7	Массив	Массивын тухай үндсэн ойлголт Массивыг зарлах, үүсгэх, ашиглаж сурах Массивийн элементүүдийг давталтаар боловсруулах
7	Байгуулагч функц	Функцын тухай үндсэн ойлголт Байгуулагч функц түүний хэрэглээ
8	String классын функцууд	Mate классыг хэрхэн ашиглах Тэмдэгт мөр String классын функцууд
9	Бүрдмэл харьцаа	Хэрхэн ашиглагддаг вэ ? Гишүүн өгөгдөл хэлбэрээр Параметр хэлбэрээр Буцаах төрөл хэлбэрээр Класс зохион байгууулах Классын үйлдэл дотор объект зарлах байдлаар бүрдмэл харьцааг ашиглах
10	Удамшил	Эцэг болон хүү класс Хүү классын байгуулагч функц

		Өөрийн онцлог өгөгдөл, үйлдэл нэмэх Super болон this түлхүүр үг Дарж тодорхойлох, түүнээс татгалзах
11	JVM буюу Жава виртуал машин	Виртуал машин гэж юу вэ ? Виртуал машины Флатформууд
12-16	Бататгах хичээл болон шалгалтанд бэлдэх	Хичээлүүдээ дахин давтаж бататгах, Тест бөглөн мэдлэгээ солилцон, ойлгогдоогүй зүйлсын талаар ярилцана.

5. Хичээлийн оролцоо

Өмнөх семистрүүдэд орж байсантай адил ирцийг дүгнэх боломжгүй тул Youtube хичээлийн нийт үзэлтээр оролцоог үнэлж байна. Хүснэгт 3-аар хичээлүүдийн нийт үзэлтийг харуулав.

Хичээлүүдийн үзэлт нь орсон хугацаанаасаа хамааран буурч байгаа бөгөөд цаашид өсөх хандлагатай гэж үзэж байна.

Хүснэгт 3. Youtube хичээлийн үзэлт

№	Хичээл	Хичээлийн нэр	Нийт үзэлт
1	Програмчлалын үндэс	Алгоритм, if else нөхцөл шалгалт	744
2		Operator, үйлдэл	428
3		Loop, while давталт	570
4		Loop, while давталт	570
5		For, do-while давталт	672
6		Switch	129
7	Объект хандлагат програмчлал	Танилцуулга хичээл	722
8		Хувьсагч, өгөгдлийн төрөл, main функц	276
9		Оператор , Scanner class	162
10		If, else , switch Нөхцөл шалгах үйлдлүүд	82



6. Хичээлийн дэлгэрэнгүй тайлан

6.1. Хичээлийн огноо: 10 сарын 20 нд

Хичээлийн сэдэв: Програмчлалын үндэс | Алгоритм, if else нөхцөл шалгалт

Үзэлт: 744

Нэмэлт тайлбар: С хэлний эхний гурван хичээл өмнөх семистерт Youtube сувагт байршсан тул шууд үргэлжлүүлэн орсон. Сэдвийн хүрээнд онол, практик хослуулан, бодлого бодох замаар заасан.



Зураг 4.1.1. 10.20-ны хичээл Youtube хандалт Зураг 4.1.2. 10.20-ны хичээл Facebook post хандалт

6.2. Хичээлийн огноо: 10 сарын 22 нд


Хичээлийн сэдэв: Объект хандлагат програмчлал | Танилцуулга хичээл

Үзэлт: 722

Нэмэлт тайлбар: Эхний хичээл нь Жава хэлний талаар ерөнхий ойлголтыг онолын байдлаар орсон. Presentation дээр үзүүлэн хичээлийн зарчмаар орсон хичээл юм.



Зураг 4.1.3. 10.22-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.4. 10.22-ны хичээл Facebook хандалт

6.3. Хичээлийн огноо: 10 сарын 27 нд


Хичээлийн сэдэв: Програмчлалын үндэс | operator, үйлдэл

Үзэлт: 428

Нэмэлт тайлбар: Операторын талаар



Зураг 4.1.5 10.27-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.6. 10.27-ны хичээл Facebook хандалт

6.4. Хичээлийн огноо: 11 сарын 11 нд


Хичээлийн сэдэв: Объект хандлагат програмчлал | Хувьсагч, өгөгдлийн төрөл, main функц

Үзэлт: 276

Нэмэлт тайлбар: Жава хэлний үндсэн ойлголтууд болох хувьсагч , өгөгдлийн төрөл, мөн main функцийн талаар ойлголтыг онол , практик хослуулан заасан.



Зураг 4.1.7. 11.01-ний хичээл Youtube хандалт




Зураг 4.1.8. 11.01-ний хичээл Facebook хандалт

6.5. Хичээлийн огноо: 11 сарын 03 нд


Хичээлийн сэдэв: Програмчлалын үндэс | loop, while давталт

Үзэлт: 571

Нэмэлт тайлбар: Давталтуудын талаар авч үзсэн.



Зураг 4.1.9. 11.03-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.10. 11.03-ны хичээл Facebook хандалт

6.6. Хичээлийн огноо: 11 сарын 17 нд


Хичээлийн сэдэв: Програмчлалын үндэс | for, do-while давталт

Үзэлт: 673

Нэмэлт тайлбар: Давталтуудын талаар авч үзсэн.



Зураг 4.1.11. 11.17-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.12. 11.17-ны хичээл Facebook хандалт

6.7. Хичээлийн огноо: 11 сарын 19 нд


Хичээлийн сэдэв: Объект хандлагат програмчлал | Оператор , Scanner class

Үзэлт: 162

Нэмэлт тайлбар: Оператор болон Scanner классын талаар практикт суурилсан хичээл орсон.



Зураг 4.1.13. 11.19-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.14. 11.19-ны хичээл Facebook хандалт


6.8. Хичээлийн огноо: 11 сарын 24 нд

Хичээлийн сэдэв: Програмчлалын үндэс | Switch

Үзэлт: 132



Зураг 4.1.15. 11.24-ны хичээл Youtube хандалт




Зураг 4.1.16. 11.24-ны хичээл Facebook хандалт

6.9. Хичээлийн огноо: 12 сарын 03 нд


Хичээлийн сэдэв: Объект хандлагат програмчлал | If, else , switch Нөхцөл шалгах үйлдлүүд

Үзэлт: 84

Нэмэлт тайлбар: If else болон Switch-ын талаар авч үзсэн.




Зураг 4.1.17. 12.03-ны хичээл Youtube хандалт



Зураг 4.1.18. 12.03-ны хичээл Facebook хандалт

6.10. Discord Server

Клубийн discord server-т нийт 250 гаруй оюутан элссэн бөгөөд сургалттай холбоотой тусдаа суваг гаргаж өгснөөр асуух зүйлсээ асуух, чөлөөтэй харилцах боломж олгосон юм.



Зураг 4.1.19. Discord server

7. Дүгнэлт

“Програмчлалын үндэс” болон “Объект хандлагат програмчлал” хичээлийн хүрээнд ШУТИС-МХТС-ын оюутнуудад орсон програмчлалын хэлний хичээлүүд нь танхимаар орох боломжгүй болсон тул youtube сувгаар дамжин орж, дунджаар 500 орчим үзэлттэй байна. Танхимаар орсонтой харьцуулахад амьд харилцаан дээр суурилан, суралцагчидтай харилцах боломж бүрдээгүй ч Discord ашиглан харилцаж байсан тул харьцангуй асуудал бага байсан. Мөн хичээлүүдийг танхимаар нэг удаа заагаад дуусгах бус Youtube суваг дээр байршуулсан нь танхимын сургалттай харьцуулвал хаанаас ч, хэзээ ч, хэдэн ч удаа үзэж болох боломж нээгдэж байгаа. Мөн зөвхөн манай мэргэжлийн оюутнууд бус зорилтот бүх хүнд хүрэх контент болж байгаа нь маш том давуу тал юм. Сургалтын бичлэгүүд одоо ч үргэлжлэн хийгдэж байгаа бөгөөд цаашдаа хичээлүүд маань цахим сувгуудаар орсоор байх юм.

4.2 Дотоод суралт

Дотоод сургалт нь клубын идэвхтэн гишүүд рүү чиглэгдэн явагддаг.

4.2.1. Арилжааны техник шинжилгээний сургалт

“Sys&CoTech” клубийн 2020-2021 оны намрын улирлын “Арилжааны техник шинжилгээ хийж сурах” дотоод сургалтын хичээлийн тайлан.

1. Сургалтын зорилго

Sys&CoTech клубын оюутнуудад зах зээлийн ханшийн график дүрслэл дээр зүй тогтлыг ойлгох, техник шинжилгээ хийж сурах анхан шатны мэдлэгийг олгоход оршино.

2. Зорилт

- Зах зээлийн ханшийн график хэрхэн хөдөлдөг зүй тогтлыг ойлгох
- техник шинжилгээг анхан шатны түвшинд сурах
- техник шинжилгээн дээр үндэслэсэн шийдвэр гаргаж арилжаанд оролцох

3. Хичээлийн талаар ерөнхий мэдээлэл

Энэхүү хичээл нь бидний мэдэх зах зээл дээрх “бүтээгдэхүүн, валютын хослол

crypto” чартан дээр анализ хийж түүн дээр үндэслэсэн шийдвэр гаргаснаар ашиг хүртэх боломжийг олгох ба тус хичээлийг мэдээллийг технологийн 4-р дамжааны оюутан Х. Аманбай 9 долоо хоногийн турш багшлан явуулах ба долоо хоног бүрийн мягмар гарагт 18:30 - 20:00 цагийн хооронд цахимаар болон танхимаар явагдана.

4. Хичээлийн төлөвлөгөө

Хүснэгт 1-т үзүүлсэн төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан.

Хүснэгт 1. Хичээлийн төлөвлөгөө

Долоо хоног	Сэдэв	Агуулга
7	Хөрөнгийн зах зээлийн тухай	<ul style="list-style-type: none"> ● бид юуг арилжаалдаг вэ? ● эдийн засгийн зарим ойлголтууд <ul style="list-style-type: none"> ➢ Бодлогын хүү, инфляци, нийлмэл хүү энгийн хүү ➢ санхүүгийн 4 тэнхлэгийн талаар ● хөрөнгийн биржүүдэд арилжаа хэрхэн явагддаг вэ? <ul style="list-style-type: none"> ➢ эрэлт нийлүүлэлт ➢ NYSE, LONDON, SYDNEY, TOKYO гэж юу вэ? ● forex, crypto, stocks ● Брокер гэж юу вэ? ● техник болон суурь шинжилгээ тэдгээрийн ялгаа
8	Техник шинжилгээ day1	<ul style="list-style-type: none"> ● чарт гэж юу вэ? <ul style="list-style-type: none"> ➢ чартын төрлүүд ➢ tradingview ● candlestick <ul style="list-style-type: none"> ➢ candle-ийн бүтэц ➢ bearish bullish candle ● timeframe гэж юу вэ?
9	Техник шинжилгээ day2	<p>Тренд гэж юу вэ?</p> <ul style="list-style-type: none"> ● uptrend ● downtrend ● range хөдөлгөөн ● dow theory
10	Техник шинжилгээ day3	<ul style="list-style-type: none"> ● support ● resistance ● channel ● trendline

11	Candlestick pattern	<ul style="list-style-type: none"> ● bearish candle ● bullish candle ● Dow theory+sup&res+trendle+candlestick pattern(бататгал хичээл)
12	Chart pattern	<ul style="list-style-type: none"> ● pattern гэж юу вэ? ● correction-ий талаарх ойлголт ● impluse-ийн талаарх ойлголт ● доошоо болон дээшээ задардаг pattern
13	entry хэрхэн хийх вэ?	break out , pullback+test, risk entry
14	хослолуудын хоорондын хамаарал болон арилжааны сэтгэл зүй, арилжаачны төрлүүд	<ul style="list-style-type: none"> ● Метал түүхий эд ● валют хослол ● крипто ● индексүүд ● scalp, day, swing, position арилжаанууд
15	Техник шинжилгээний tool-үүд тэдгээрийн хэрэглээ	fibonacci retracement + andrew's pitchfork

5. Хичээлийн дэлгэрэнгүй тайлан

Хичээл нь нийт 3 удаагийн оролтоор 4 бүлгийн агуулгыг орсон ба багшлагч оюутны эрүүл мэндийн шалтгаан клубын албан үйл ажиллагаанаас шалтгаалан агуулгаа бүрэн дуусгаагүй улирлын амралтын хугацаанд Youtube-р үргэжлүүлэн бичлэг хэлбэрээр орох болно.

Хичээл 1

Хичээлийн огноо: 10 сарын 12

Хичээлийн сэдэв: Хөрөнгийн зах зээлийн тухай

Оролцсон оюутан: 10 оюутан

Нэмэлт тайлбар: энэ хичээл дээр хөрөнгийн зах зээл яаж ажилладаг цикл мөнгөний талаарх ойлголтууд эдгээрийг мэдсэнээр ямар ач холбогдол давуу талтайг дэлгэрэгүйгээр тайлбарласан.



Зураг 4.2.1. 10.12-ны хичээл


Хичээл 2

Хичээлийн огноо: 10 сарын 19

Хичээлийн сэдэв: Чарт, candlestick, timeframe, dow theory

Оролцсон оюутан: 6 оюутан

Нэмэлт тайлбар: Энэ удаагийн хичээлийг цахимаар discord ашиглаж орсон ба техник шижилгээний хамгийн суурь ойлголт болох dow theory, trend гэх зүйлийг бодит чартан дээр харуулж заасан.



Зураг 4.2.2. 10.19-ны хичээл

Хичээл 3

Хичээлийн огноо: 11 сарын 05

Хичээлийн сэдэв: Trendline support болон resistance

Оролцсон оюутан: 5 оюутан

Нэмэлт тайлбар: уг хичээлээр өмнөх хичээлээр үзсэн ханшин чиг хандлага дээрээ уялдуулан ханшин эсэргүүцэл болон дэмжлэгийн бүсүүд хаана байрлах тэдгээрийг олж зурж сурах ингэснээр ханш хаашаа ямар чиглэлтэй, аль цэгт хүрээд буцах, өсөх буурах зэрэг ирээдүйд болох зүйлийг магадлалаар урьдчилан таамаглах юм.



Зураг 4.2.3. 10.21-ны хичээл

6. Дүгнэлт

Арилжааны техник шинжилгээ хичээлээр нийт 9 бүлэг хичээлийг 9 долоо хоногийн турш заах төлөвлөгөөтэй байсан ба үүнээс 3 удаагийн оролтоор 4 бүлэг хичээлийг орсон. Тус хичээлүүдийг онолын мэдлэгийг өгсөний дараа практик дээр бодит ханшийн график дүрслэлд зурж тайлбарлан үзүүлсэн нь олсон мэдлэгээ бататгах мөн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг нэг шатаар ахиулсан. Нийт сургалтын хүрээнд тогтмол 5-9 хүн суусан бөгөөд Sys&CoTech клубын дотоод үйл ажиллаанд багахан ч болоо хувь нэмэр оруулсан сургалт хичээл байлаа.

4.2.2. Жаваскрипт сургалт

“Sys&CoTech” клубийн 2020-2021 оны намрын улирлын “Жаваскрипт хэл” хичээлийн тайлан

1. Зорилго

Sys&CoTech клубын оюутнуудад “Жаваскрипт” хэлийг анхан шатнаас дунд шат хүртэл заах, тухай хэлний хэрэглээ, синтакс, ашиглалтыг суралцахад туслах зорилготой.

2. Зорилт

- Жаваскрипт хэлийг судлах
- Веб хийх явц дээр суурилан Жаваскрипт хэлийг ашиглах
- Жаваскрипт хэлийг ашиглан веб дээрх үйлдлүүдийг хийх

3. Хичээлийн талаар ерөнхий мэдээлэл

Өөрийн их сургуулийн хичээлээр олж авсан мэдлэг болон хувийн туршлага дээрээ үндэслэн Жаваскрипт хэлний хичээлийг заасан. Багшлагч оюутан:

- Мэдээллийн технологийн 4-р курсийн оюутан О. Ринчиндугар (В180930008) заасан. Долоо хоног бүрийн лхагва гарагуудад 18:30 - 20:30 цагийн хооронд цахимаар явагдана.

4. Хичээлийн төлөвлөгөө

Хүснэгт 1-т үзүүлсэн төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулсан. Хөл хорионы улмаас 12-16 –р долоо хоногийн агуулгыг цахимаар орно.

Хүснэгт 1. Хичээлийн төлөвлөгөө

Долоо хоног	Сэдэв	Агуулга
7	Javascript хэлтэй танилцах	JavaScript хэлний үүсэл хөгжил хэрэглээний тухай үндсэн ойлголт.
8 - 9	JavaScript суурь ойлголтууд	Хувьсагч болон өгөгдлийн төрлийн тухай үндсэн ойлголт Хувьсагч зарлах, өгөгдлийн төрөл тодорхойлох, ашиглаж сурах IF, ELSE тухай үндсэн ойлголт Функциг хэрхэн ашиглах Функц тодорхойлох
10 - 11	DOM - ын тухай ойлголт	JavaScript дээрх DOM тухай ойлголтууд <ul style="list-style-type: none"> ● HTML element - рүү хандах ● HTML Element үүсгэх ● Event listener (mouse event, keyboard input)

11 - 12	DOM ашиглан project хийж үзэх (Task)	Сурсан JavaScript DOM ашиглан Ажил төлөвлөх project хийж үзэх болно. <ul style="list-style-type: none"> List, Delete, Add үйлдэлтэй
13	Reactjs	JavaScript хэлний framework болох Reactjs - ийн тухай ойлгох. Шинэ Reactjs project үүсгэж ажилуулж сурах
14-16	Reactjs Project	Reactjs дээр project үүсгэх. <ul style="list-style-type: none"> state & props ойлголт Functional component Package суулган ашиглах (npm package manager)


5. Хичээлийн дэлгэрэнгүй тайлан

Хичээлийн огноо: 10 сарын 13

Хичээлийн сэдэв: Жаваскрипт хэлний танилцуулга

Оролцсон оюутан: 9 оюутан

Нэмэлт тайлбар: Эхний хичээл дээр Жаваскрипт хэлний үүсэл, хөгжил, ашиглалт болон ямар салбаруудад хэрхэн хэрэглэж болох тухай бодит жишээ нь дээр тулгуулан тайлбарлан ярилцсан.




Зураг 4.2.4. 10.13-ны хичээл

Хичээлийн огноо: 10 сарын 28

Хичээлийн сэдэв: JavaScript суурь ойлголтууд

Оролцсон оюутан: 6 оюутан

Нэмэлт тайлбар: Хувьсагч зарлах, өгөгдлийн төрөл тодорхойлон ашиглаж сурах. Тухай төрлийн төрлөөс хамааран хийж болох нэмэлт үйлдлүүд, боломжуудыг ашиглах. Web console - той танилцах.



Зураг 4.2.5. 10.28-ны хичээл

Хичээлийн огноо: 11 сарын 03

Хичээлийн сэдэв: Функц түүний хэрэглээ

Оролцсон оюутан: 9 оюутан

Нэмэлт тайлбар: JavaScript хэл дээр хэрхэн фунцыг зарлах ашиглах боломжуудыг тайлбарлан жишээ гүйцэтгэсэн.

Хичээлийн огноо: 11 сарын 10

Хичээлийн сэдэв: DOM - ын тухай ойлголт

Оролцсон оюутан: 8 оюутан

Нэмэлт тайлбар: DOM ашиглан HTML - ийн элементүүдийг удирдах. Method, document, element, css, Event listener ашиглалтын талаар суралцсан.



Зураг 4.2.6. 11.10-ны хичээл

Хичээлийн огноо: 11 сарын 17

Хичээлийн сэдэв: DOM ашиглан project хийж үзэх

Оролцсон оюутан: 7 оюутан

Нэмэлт тайлбар: Сурсан JavaScript DOM ашиглан List, Delete, Add үйлдэлтэй ажил төлөвлөх project хийж үзсэн.



Зураг 4.2.7. 11.17-ны хичээлийн үр дүн

Хичээлийн огноо: 11 сарын 24

Хичээлийн сэдэв: Reactjs

Оролцсон оюутан: 5 оюутан

Нэмэлт тайлбар: Өмнөх хичээлүүдийн мэдлэг дээр тулгуурлан Javascript - ийн framework болох Reactjs - ийн талар ярилцаж. Анхны Reactjs project - ийн үүсгэж ажлуулсан, project - ийн архитектуртай танилцсан.



Зураг 4.2.8. 11.24 - ны хичээл

Хичээлийн огноо: 12 сарын 01

Хичээлийн сэдэв: Reactjs Project

Оролцсон оюутан: 5 оюутан


Дүгнэлт

Жаваскрипт хэлний сургалтаар HTML, CSS - ийн мэдлэг дээрээ тулгуурлан Жаваскрипт хэлний үндсэн ойлголтуудыг суралцсан. Мөн жижиг хэмжээний програм хэрэгжүүлж явсан нь тухай сурсан зүйлсээ баталгаажуулж явсан нь суралтын үр дүнтэй байсан.



5. Дотоод үйл ажиллагаа

5.1. Цэвэрлэгээ


Халдварт өвчний үед өрөөний ариун цэврийг сахиулах, гишүүдийн эрүүл мэндэд анхаарах үүднээс клубийн өрөөндөө гар ариутгагч шингэн болон гар ариутгагчийн сав, ариутгалын бодисууд авсан ба вирусээс урьдчилан сэргийлэх зөтлөмжүүдийг гаргасан. Мөн долоо хоног тутам 2 удаа жижүүрийн хуваарийн дагуу өрөөндөө бүрэн цэвэрлэгээ хийж байсан.



Зураг 5.1.1. Цэвэрлэгээ, ариутгал



Зураг 5.1.2. Цэвэрлэгээ



Зураг 5.1.3. Цэвэрлэгээ



Зураг 5.1.4. Санитол


5.2. Багуудын үйл ажиллагаа

Клубийн гишүүдийн ур чадварыг хөгжүүлэх зорилгоор энэ улиралд клубийн гишүүдийг багт хуваасан. Үүнд:

1. Хөгжүүлэлтийн баг: Веб хөгжүүлэлтийн чиглэлээр өөрсдийн клубийн вебийн хөгжүүлэлт хийж, гишүүддээ дотоод сургалт орсон.




Зураг 1.1 Java Script-дискорд сургалт




Зураг 1.2 <https://www.syscotech.club> Клубын веб сайт


2. Сошиал баг: Хичээлийн видео контент бүтээж, клубийн фейсбүүк хуудсанд өдөр бүр мэдээллийн технологийн салбартай холбоотой мэдээ бэлтгэн тасралтгүй оруулж байна.



Зураг 2.1 Програмчлалын олимпиадын мэдээлэл



Зураг 2.2 Сошиал багийн хөгжүүлдэг Instagram хуудас



Зураг 2.3 Сошиал багийн хөгжүүлдэг YouTube channel

- Загварын баг: График дизайн чиглэлээр дотоод, гадаад үйл ажиллагааны постер зар бэлтгэж, “adobe” програмууд дээр ажиллаж сурч байна.



Зураг 3.1 Загварын багийн гаргадаг цом загвар




Зураг 3.2 Загварын багийн гаргадаг өргөмжлөл загвар


- Энтертаймент баг: Контент хөгжүүлэлт чиглэлээр үйл ажиллагаатай холбоотой видео хийх, зураг авах, баримтжуулах ажлуудыг хийдэг.



Зураг 4.1 Энтертаймент багийн спорт өдөрлөгөөр хийсэн видео



Зураг 4.2 Энтертаймент багийн хөгжүүлдэг Instagram хуудас



Зураг 4.3 Энтертаймент багийн хөгжүүлдэг YouTube channel

5.3. Дугуй ширээний ярилцлага, “Photo memories challenge”

Клубыг дотоод харилцааг сайжруулах, гишүүд хоорондын дотно байдлыг нэмэгдүүлж эв нэгдэлтэй, нэг зорилготой чадварлаг хамт олон байх, гишүүдийг идэвхжүүлэх зорилгоор “Photo memories challenge”, дугуй ширээний ярилцлага 2 долоо хоногт нэг удаа зохион байгуулсан.



Зураг 5.3.1. Дугуй ширээ



Зураг 5.3.2. Дугуй ширээ



Зураг 5.3.3. Дугуй ширээ



Зураг 5.3.4. Photo memories challenge

WHIZZ КЛУБИЙН ТАЙЛАН

Клубийн танилцуулга

“WHIZZ” клуб нь 2005 оноос хойш дизайны тэнхимийн эрхлэгч Д. Түмэнболд, ахлах багш Б. Мэндсайхан ба О. Гантулга, А. Цэрэндулам багш нарын удирлага дор оюутны хөгжил төлөвшил, мэргэжлийн ур чадвар, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд анхааран үйл ажиллагаагаа явуулж байгаа мэргэжлийн клуб билээ.

Клубийн зорилго:

- Компьютер график дизайн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад тухайн мэргэжилийг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, дизайны хичээлийн онолын мэдлэгээ туршиж бататган, практикт хэрэгжүүлэх мөн өөр хоорондоо танилцаж танилын хүрээгээ өргөжүүлэх зорилготой.
- Дизайны мэргэжилийг бусдад таниулах, үнэлүүлэх, сурталчилах, өргөжүүлэх зорилготой.

Клубийн зорилт:

- Оюутан залуусын суралцах идэвхи, сонирхлыг дээшлүүлэх, гоо зүйн ойлголтыг бусаддаа танин мэдүүлэх, мэргэжилээ сурталчилах зорилгоор мэргэжилийн уралдаан тэмцээн зохион байгуулах.
- Багш, оюутнуудын шинээр гаргасан уран бүтээлийг сурталчилан үзэсгэлэн зохион байгуулах.
- Оюутнууд компьютер график дизайны шинэ хичээл судлаж, бусдад таницуулах.
- Дээд болон доод курсын оюутнуудыг хооронд нь холбож, харилцан биеэндээ зөвлөгөө өгөх, туршлага солилцох бололцоог бий болгох, хамтран ажиллах боломжоор хангах.
- ШУТИС-ийн хэмжээнд болон бусад их дээд сургуулиудын тэргүүлэх оюутны клуб болох.
- Холбогдох гадны болон дотоодын байгууллагуудтай туршлага, мэдээлэл солилцож, мэргэжлээ таниулан хамтран ажиллах.

WHIZZ клуб нь нийт 84 гишүүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна:

- 1 дугаар курсын 16 оюутан
- 2 дугаар курсын 14 оюутан
- 3 дугаар курсын 20 оюутан
- 4 дүгээр курсын 34 оюутан



Дотоод үйл ажиллагаа. Клубийн гишүүдийн идэвхижүүлэлт.

Ойрын зайн явган аялал /Мишээл экспо - walking street/

Шинээр элссэн гишүүддээ клубийн зорилго танилцуулгийг хийсэн ба Вийз клубд байсан төгсөгчидөөс ирж ирээдүйд клубээ хэрхэн сайжруулах талаар ярилцсан. Дээд болон доод мөн төгсөгчидтэй танилцаж дотносуулах анхны алхамаа хийсэн. Хоорондоо тоглож хөгжилдөж ямар чиглэлээр мэргэжилээ гүнзгийрүүлэхэв талаар ярилцаж үр бүтээлтэй өнгөрүүлсэн.

Оролцсон оюутны тоо: 22

2021.10.24




Кино үдэш ба хэлэлцүүлэг

/2021.10.29 – 2021.12.3/

Баасан гариг болгоны орой 20:00 цагаас клубын дискорд серверд дэлгэцээ share хийж киногоо үздэг ба үзэж дуусаад киноныхоо тухай хамтдаа ярилцаж мэргэжилийн үүднээс тайлбар хийн мэтгэлцэж өнгөрөөдөг. Мэтгэлцээний дараа сонирхолтой нэгэн асуулт асууж эхэнд хариулсан хүн дараа долоо хоногийн киног сонгох эрх үүсдэг.

Үзсэн кинонууд:


- Худалдагч охин
- Lost in translation
- Her
- Never let me go
- Kenshin the Eagle
- 1917




/Дараагийн үзэх киноны талаар ярилцаж байна/

Лобби

Хагас болон бүтэнсайнаар Valorant, CSGO, DOTA2 зэрэг тоглоомуудаар лобби босгон оюутнууд, төгсөгчид мөн багш нартайгаа тоглож өнгөрөөдөг.



Оюутнууд хичээлээ хийхдээ дискорд дээр дэлгэцээ шарэ хийж бусаддаа мэдлэгээ хуваалцдаг ба багийн ажиллуудаа тус тусын өрөөнд орж хурдан хугацаанд цаг алдалгүй хуваалцаж бусдаасаа суралцаж чаддаг. Дээд күрсийнхэн болон багш нар мөн төгсөгч нараасаа мэдэхгүй зүйлсээ хурдан хугацаанд асууж авах зэрэг маш олон давуу талуудтай.




Дотоод үйл ажиллагаа. Мэргэжлийн үйл ажиллагаа.

Тогтмол зохион байгуулдаг чалленжууд /2021.10.25 – 2021.12.6/

Долоо хоног болгоны даваа гариг бүрд хичээлийн хажуугаар хийхэд саад учруулахгүй жижиг чалленжуудын зохион байгуулдаг ба чалленжид оролцоход хүн болгон 1000 төгрөг хураалгаж оролцдог ба чалленжийн ялагч бүх мөнгийг өөртөө авдаг уламжлалыг тогтоогоод байна.

Явуулсан чалленжууд:

- ШУТИС -ын бренд бүтээгдэхүүн гаргах
- Клубын өрөөг тохижуулах санаа гаргах
- Клубын нэрийн стикер гаргах
- Клубын гишүүдийн цамцны загвар гаргах
- Дараа семистер эхлүүлэх контентын санаа уралдуулах
- Youtube channel -д ямар бичлэг хийх вэ?



ГАДААД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэргэжлийн үйл ажиллагаа ШУТИС Design Vitality – Хакатон /2021.10.27 – 2021.10.29/

Анхны монголын дизайны салбарын оюутны намрын улиралд явагддаг бүх их, дээд сургуулийг хамарсан тус тэмцээний арын ажил болон зохион байгуулагчдаар оролцсон.

Оролцсон оюутны тоо: 6



Ажлын дарсан зураг/

ШУТИС-ийн бренд бүтээгдэхүүн

/2021.10.29 – 2021.11.11/

ШУТИС -ын нэрийн нийт 9-н бүтээгдэхүүн гаргаж түүн дээр байх загваруудыг гаргаж нийт 15н загвар 50н стикерны загвар гаргасан.

9-н бүтээгдэхүүнд:

- Цамц
- Подволк
- Аяга
- Үзэг
- Тэмдэглэлийн дэвтэр
- Стикер
- Малгай
- Хувцасны цүнх
- Усны сав зэрэг бүтээгдэхүүнүүд багтана.

Оролцсон оюутны тоо: 46



#SAVEMUNKHUU хандивын аян

/2021.12.06 – 2021.12.10/

Клубуудын нэгдсэн зөвлөлөөс санаачилсан нэгэн ШУТИС -ын оюутанд зориулан хандивын аянд манай клуб оролцож дэмжлэг үзүүлсэн болно.

Оролцсон оюутны тоо: 4



КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Энэ улирлын хувьд

Цар тахалаас хамааралтайгаар мөн WHIZZ клуб нэг жил амралтын байдалтай байсан гэх 2 шалтгааны улмаас энэ улиралд клуб доторх уур амьсгалын сайжруулах, дотносуулах, найзууд болгох мөн мэргэжилээ танин мэдэх сонирхолын татах, дурлуулах зорилготойгоор аль болох бага мэргэжилийн ажил хийсэн ба энэ маань үр дүнгээ маш сайн өгсөн гэж дүгнэж байна. Ангийнхаа хамт олныг ч бүрэн танихгүй байсан хүүхдүүд одоо нэгнээ танидаг болхоос гадна дээд курс доод курсийнхий харилцаа маш дотно болсон. Энэ бол манай клубын гол 2 зорилгын нэг бөгөөд хамгийн чухал зүйл минь билээ. Тийм учир энэ улиралд бид сэтгэл хангалуун байна.

Дараа улирлын төлөвлөгөө

Бидний зохион байгуулдаг Алтан хулгана тэмцээн дараа улиралд буюу 5 -н сард анх удаагаа цахимаар зохиогдох гэж байгаа ба бид веб ийнхээ ажилд дээд курсийнхэн болон багш нар маань ажилдаа орсон байгаа. Мөн ирэх улиралд алтан хулганаас өмнө алтан хулганы фэйсбоок болон инстаграм хаягуудыг хөгжүүлэх болно. Түүний хажуугаар нэгэн контент хийх санаатай байгаа ба подкаст, видео контент гэх мэт ажиллуудыг эхлүүлэх болно. Ирэх улиралд аль болох мэргэжилийн ажилуудыг эхлүүлэх болно мөн алтан хулгана -ыг амжилттай зохион байгуулах гэсэн 2 зорилт тавин ажиллах болно.

“ЗАЛУУ ЭКОЛОГИЧ” КЛУБИЙН ТАЙЛАН

Залуу экологич клубийн танилцуулга

Тус клуб нь 2015 онд Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн үйлдвэр экологийн мэргэжил дээр тулгуурлан байгуулагдаж байсан ба одоогоор дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагаа:

- Мэргэжлийн багш нараас лекц, зөвлөгөө авах;
- Сонирхолтой лекц, сургалт зохион байгуулах
- Үйлдвэр, лабораториудтай очиж танилцах
- Экологи, байгаль хамгаалал болон түүний салбар ШУ-ны талаарх сүүлийн үеийн ололт амжилтуудын талаар мэдээлэл авах, харилцан солилцох;
- Тэмцээн уралдаан болон ЭШХ-д баг хамт олноороо оролцох
- Чөлөөт цагийг сонирхолтой өнгөрүүлж, найз нөхдийг хүрээг тэлэх
- Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд идэвхитэй оролцох

Клубийн зорилго

Мэргэжлийнхээ чиглэлээр илүү ихийг сурах эрмэлзэлтэй “Хүрээлэн буй орчин болон экологийн салбар шинжлэх ухааны ” чиглэлээр суралцаж буй болон шинийг эрэлхийлэгч идэвхтэн оюутан залуусыг нэгтгэн байгальд ээлтэй чадварлаг мэргэжилтэн, боловсон хүчин болоход нь тусалж дэмжихэд оршино.

Бүтэц зохион байгуулалт:

Клубийн ахлагч: Б.Нямдарь, О.Халиун

- **Залуу экологич клуб** нь удирдах зөвлөлийн 10 гишүүн болон идэвхитэн 40 гишүүдээс бүрдэнэ.
- **Удирдагч багш:** Д.Номиндарь, О.Энхцолмон, Н.Чимэдцогзол
- **Зөвлөх багш:** С.Туяа, Б.Булгансайхан, Г.Мөнхсайхан, Ч.Даваасүрэн

Клубийн зохион байгуулсан үйл ажиллагаа

Клубийн үйл ажиллагааг 2021 оны 10 сарын 1 нд эхний хурлаа цахимаар хийсэн нээсэн ба 2021-2022 оны төлөвлөгөөг боловсруулсан.

Залуу экологич клубийн багш оюутнууд дунд уламжлал болсон "Эко аялал"-4 /2021.10.02/

Богд уулруу явган аялал хийж шувууны үүр өлгөх боломжгүй байсан учраас харуулд нь хүлээлгэн өгсөн.Мөн хөгжөөнт тоглоом тоглосон ба Экомайндын гишүүд гээд 100 гаруй хүүхэд 2 чиглэлд хуваагдан аяласан.





зураг 1. Уламжлалт эко аялал "Богд хаан ууланд"

Аялалын үеэр клубийн гишүүдийн хийж ирсэн нь шувууны үүрийг Богд уулын байгаль хамгаалагчид хандивласан бөгөөд хамгийн гоё дулаан шувууны үүр хийж ирсэн гишүүнээ шагнаж урамшуулсан. Уулнаас буухдаа ойр орчмын болон замдаа таарсан хогийг түүж, цэвэрлэж хогийн цэгт хаясан зэрэг үйл ажиллагаануудыг явуулж, нэг өдрийг үр бүтээлтэй хөгжилтэй өнгөрөөсөн.

“Зочны цаг” /2021.10.09/

Экомайнд ТББ-тай хамтран Байгаль орчин, инженерийн чиглэлийн багш мэргэжилтэн судлаачидыг урьж оюутнуудад зориулсан сургалт, семинарыг Тусгаар тогтнолын ордонд зохион байгуулсан.

ECOMIND ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ

ХЭТЛЭГЧ: Н.ЛХАГВАБАЯР	МЭЭХОЛБОО, БИОЛОГИ ХЭДЭЭ АЖ АХУЙН САЛБАР ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ С.ЖАВХЛАН	МУИС-ИЙН БАГШ ДОКТОР ДЭД ПРОФЕССОР Б.ОЮУНСАНАА	БОСШТӨВ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАЯРБАТ	ЭКО МАЙНД ТББ ТЭРГҮҮН Ё.ГАНТӨГС

ЭКО МАЙНД ДЭЛХИЙГ АВАРНА

ТУСГААР ТОГТНОЛЫН ОРДОН 2021.10.09

зураг 2. Экомайнд ТББ зочин илтгэгчид



зураг 3. Сургалтаа сонсож буй оюутнууд

Сургалтын үеэр зочин илтгэгчид өөрсдийн бэлтгэсэн илтгэлээ танилцуулж сургалтын төгсгөлд хэлэлцүүлэг өрнүүлж оюутнуудтайгаа нээлттэй ярилцлаа. Илтгэгч Жавхлан эгч маань “Хаг судлал”-ын талаар ярьсан бол илтгэгч Оюунсанаа ах маань “Гал түймэр” зэрэг сэдвээр ярьсан.

1.3. Залуу экологич клубийн гишүүдээ “Нэг хүүхэд нэг мод” аянаа “Нэг тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөнд оролцохоор өөрчилсөн. Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарих өдөрлөгт гишүүдээ оролцуулсан. Хөдөлгөөний хүрээнд Экомайндын гишүүд болон клубын 6 гишүүн 50 ширхэг мод тарьсан.



зураг 4. Бүх нийтийг мод тарих өдөр



Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хичээлээс гадуурх чөлөөт үйл ажиллагааг зохиож Клубээрээ уран зургийн галерей үзэж нэг өдрийг өнгөрүүлсэн.

зураг 5. Mongol Art gallery


Клубуудийн нэгдсэн үйл ажиллагаа

Клубийн ахлагч нарын чадавхжуулах “Манлайлал” сургалтанд хамрагдав.



зураг 6. Манлайлал сургалтын үеэр

1.2 Уур амьсгалын өөрчлөлт ба оюутан залуучуудын оролцоо, санаачилга, хэлэлцүүлэг



зураг 7. Хэлэлцүүлэгийн үеэр

Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Монголын оюутны холбооноос зохион байгуулсан уг хэлэлцүүлэгт залуу экологич клубийн гишүүд оролцлоо.

Хэлэлцүүлэгийн үеэр уур амьсгалын өөрчлөлт гэж юу болох юу нөлөөлж байгаа, бид юу хийх вэ зэрэг асуудлуудыг ярилцсан.

“Залуу экологич клуб” Сэтгэлийн дэм аян




2021.12.8,9-ны өдрүүдэд оройн 19 цаг хүртэл чиглүүлэгч оюутны үүргээ биелүүлж ШУТИС-ийн II-р байрны үүдэнд хандивийн аянд оролцлоо.

Хандивын аяны хүрээнд клубийн оюутнууд маань өөрсдийн хийсэн жижиг бүтээлүүдээ зарж борлуулах байдлаар оролцлоо.

зураг 8. Хандивын аяны постер зураг

Үр дүн дүгнэлт



зураг 9. Оюутнуудын бүтээлүүд, борлуулалт хийж буй гишүүд

Уг намрын семестер төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу хийх ёстой 6 төрлийн ажилуудаас 5 ажлыг амжилттай хийсэн. Намрын семестер хийж гүйцэтгэсэн ажлуудынхаа үр дүнг шалгасан явдал маань манай клубийн ханд цаашид үйл ажиллагаагаа эрчимтэй явуулах урам зоригийг өгсөн бөгөөд сайн дурын тусламж хандивын үйл ажиллагаанд оюутан залуус маань үнэхээр чин сэтгэлээсээ идэвхи зүтгэлтэй, санаачилгатай оролцож чаддаг. Илүү олон оюутан залуусыг хамруулан сайн үйлсийн аянгаа дахин өрнүүлэх боломжтойг онцлох хэрэгтэй гэж үзлээ.

Санал хүсэлт

2021-2022 оны хичээлийн жилийн намрын семестрээс Залуу Экологич клубийг зөвлөх багшаар дамжуулан сургалт зохион байгуулах клубийн гишүүдийг идэвхжүүлэх хэрэгтэй ба сургалт зохион байгуулах анги танхим хэрэгтэй болдог.



“FINDE” КЛУБИЙН ТАЙЛАН

Танилцуулга

- ▶ ШУТИС -ҮТС-ийн үйлдвэрлэл дизайны FINDE клуб нь 2018 оны 09 сарын 17-нд албан ёсны нээлт хийж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Үйлдвэрлэлийн дизайны анхны мэргэжлийн клуб бөгөөд мэргэжлээ сурталчлах, таниулах, оюутнуудын ур чадварыг сайжруулан хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах зорилгоор нээгдсэн.
- ▶ 2018-2019 оны хичээлийн жилд үйлдвэрлэл дизайны 1, 2, 3-р курсынхныг хамруулан нийт 80 хүн элсүүлэн 35 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд 2020 оны намрын улиралд 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Клубийн зорилго, зорилт

Зорилго:


Үйлдвэрлэлийн дизайн мэргэжлийн клуб нь сонгон суралцаж буй оюутнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, өөрийнхөө бүтээлийг хамгаалах, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, мэдлэг чадварт тулгуурлан төсөлт ажил хэрэгжүүлэх ирээдүйн сайн дизайнер боловсон хүчин бэлдэхэд оршино.

Зорилт:

- ✓ Хичээлээс гадуур оюутан залуусыг хүсэл сонирхлын дагуу сургалтанд хамруулах
- ✓ Оюутнууддаа тулгамдаж буй асуудал дээр заавар зөвөлгөө өгөн, шийдэх
- ✓ Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдах
- ✓ Мэргэжлээ сурталчилан сургалт уулзалт хийх
- ✓ 1-4 курсын оюутнуудын хоорондын холбоог бататгах нэг нэгэндээ туслах, харилцан бие биендээ зөвлөгөө өгөх, туршлага солилцон, чадвараа дээшлүүлэн, нөхөрсөг өрсөлдөгч болох

Үйлдвэрлэлийн дизайны мэргэжлийн оюутнууд 3-р курстээ ороод клубийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн авч явах залгамж халааг авдаг бөгөөд цахим сургалтаас танхимын сургалт жигдэрэхэд спорт өдөрлөг зохион байгуулав.

Оюутнуудын хамрагдсан судалгаа



Оюутны хамрагдах хүрээ нь сонгон суралцаж байгаа 3-р курсын оюутнууд байдаг тул тогтмол тоотой байх боломжгүй байдаг тул элсэн суралцаж буй оюутнуудын тоог олшруулахад гол зорилго оршино.

Клубийн нэгдсэн дотоод үйл ажиллагаа

- ▶ Хамт олныг нэг зорилготой нэг хүсэл эрмэлзлийн доор нэгтгэх
- ▶ Ирээдүйн ажил мэргэжилд мэдлэг чадвар дадлага болохуйц үйл ажиллагааг явуулах
- ▶ Мэргэжлийн дагуу чиглүүлэх сургалт авах

Хамрагдах хүрээ



Үйлдвэрлэлийн дизайны 3 курсийн хамт олон



Kitchen all үйлдвэртэй танилцав




ender тавилгын үйлдвэр




Амжилттай зохион байгуулж шилжин явах цомоо гардуулав.

Цахим хичээлийн үед хийсэн зүйлс

- Танхимын сургалт цахим болсонтой холбогдуулан бид бүхэн сургалтын болоод хөгжих боломжийг алдалгүй биет болгохоос бусад бүх зүйлсийг хийж байна.



Оюутны ажил-1



Оюутны ажил-2

Мэргэжил сурталчилах клуб танилцуулах



Манай клубийн үйл ажиллагаа нь мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сайн боловсон хүчин бэлтгэх ба мэргэжлийн дагуу лабораторийн ажлууд хийх техник хэрэгсэл дээр мэргэших гэх мэт зүйлүүд дээр мэргэшдэг тул цахим орчимд ярилцан зөвхөн төслийн ажил макет боловсруулалтын ажлын зургийг л гаргах боломжтой байгаа тул өөрсдийн боломж бололцоогоор үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна.



“ЭНЕРГЕТИК” КЛУБИЙН ТАЙЛАН

Клубийн товч танилцуулга

Энергетик клуб нь 2018 оны 9-р сарын 5-нд үүсгэн байгуулагдсан бөгөөд өмнөх тэргүүнээр ДЦС-4-р курсын оюутан Э.Болдсүх ажиллаж байсан. 2021.11.17 өдөр дэд тэргүүн ДПА-3-р курсын оюутан А.Тамир тэргүүн болов. Зөвлөх багшаар ДИ салбарын ахлах багш доктор (Ph.d) А.Түмэнбаяр ажиллаж байна.

Хамрах хүрээ:

- Гишүүдийн хувь хүний хөгжил, мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- Салбарын аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжиж оролцох

Клубийн зорилго

Клуб нь гишүүдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, дулааны инженерийн салбарын манлайлагч оюутан, залуу үеийг бэлтгэхэд чиглэнэ.

Үйл ажиллагааны чиглэл

- Чадавхжуулах сургалт, мэдээлэл солилцоо
- Чөлөөт ярилцлага-лекц, мэтгэлцээнд хамруулах
- Төрөл бүрийн уулзалт, семинар зохион байгуулах
- Гишүүдийг идэвхижүүлэх арга хэмжээнүүд зохион байгуулах
- Салбарын аж ахуйн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Салбарын аж ахуй нэгж, ажил олгогчдыг төгсөгч оюутнуудтай холбох


Гишүүнчлэл

Клубын үзэл баримтлал, үйл ажиллагаа, дүрэм, журмыг сайн дураар хүлээн зөвшөөрч байгаа, дүрэмд заасан шалгуурыг хангасан залууст гишүүнчлэл нээлттэй байна. Гишүүнчлэл нь дараах төрөлтэй байна. Үүнд: Хүндэт гишүүн, Жинхэнэ гишүүн, Дэмжигч гишүүн

- Жинхэнэ гишүүн: I-III-р курсын оюутан, клубын үйл ажиллагаанд идэвхи сонирхолтой оролцох, гишүүнчлэлийн татвараа төлдөг, саналын эрхтэй гишүүд байна.
- Дэмжигч гишүүн: Клубын үйл ажиллагаанд материаллаг болон материаллаг бус дэмжлэг үзүүлэх иргэн болон байгууллагыг хэлнэ.
- Хүндэт гишүүн: Клубын үйл ажиллагааг дэмжиж оролцдог зөвлөх гишүүдийг хэлнэ.

Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа “Миний мэргэжил” сэдэвт цуврал лекц

“Миний мэргэжил”



Зураг 3.1.1 2021.09.27

Эрчим хүчний сургуулийн Дулааны инженерийн салбарын МУ-ын гавъяат багш Д.Мандалын нэрэмжит “ЭНЕРГЕТИК” клубээс уламжлал болгон жил бүр зохион байгуулдаг “Миний мэргэжил” цуврал лекцийг шинэ гишүүдэд зориулан тус клубын удирдагч багш, техникийн ухааны доктор (Ph.D) А.Түмэнбаяр “Microsoft Teams” платформуор цахимаар зохион байгуулсан. Тус лекцэнд багшаас гадна ДЦС, ДПА, ҮХДХ ангийн хоёр, гуравдугаар курсын 26 оюутан хамрагдсан. Мөн лекцийн төгсгөлд клубын гишүүдийн хооронд чөлөөт ярилцлага болж, санал бодлоо солилцов.


Миний мэргэжил “Дулааны цахилгаан станц”



Зураг 3.1.2 2021.10.13

"Миний мэргэжил" цуврал лекцийн "Миний мэргэжил-ДЦС" хэсэг "Цэнхэр зурагны эргэн тойронд" гэсэн сэдвээр "Цэцэн Майнинг энд Энержи" компанийн Бөөрөлжүүтийн цахилгаан станцын төслийн инженер Э.Даваасүрэн тавив. Төгссөн болон суралцаж буй нийт 21 оюутан, залуустай цахим хэлбэрээр хэлэлцүүлэг өрнүүлж, мэдлэг туршлагаасаа хуваалцсан ба тус лекцэнд МЭХИХ-ны гүйцэтгэх захирал, ЭХЯамны сайдын зөвлөлийн гишүүн Р.Ганжуур гуай оролцов.


Миний мэргэжил "Дулааны процессын автоматжуулалт"



Зураг 3.1.3 2021.10.23

"Миний мэргэжил" цуврал лекцийн "Миний мэргэжил-ДПА" хэсэгт "Оюу толгой ХХК"-ийн гүний уурхайн нарийн хэмжүүрийн техникч мэргэшсэн инженер, Техникийн ухааны магистр Б.Мандахбаяр "Галчаас эхэлсэн ажлын гараа минь" сэдэвтэйгээр ЗҮҮМ платформоор хүргэлээ. Тус лекцэнд ДПА ангийн 2, 3, 4-р курсын 15 оюутан оролцож мэдлэг туршлагаас нь суралцав. Мөн тус лекцэнд ЭХС-ийн ДПА ангийн 2020 төгсөгч "Оюу толгой ХХК"-ийн төв дулааны станцын зуухны операторч А.Отгонжаргал "Суралцахуйн арга туршлагаасаа хуваалцах нь" сэдвээр өөрийн суралцах хугацаанд олж авсан мэдлэг, арга барилаас хуваалцан тус чиглэлээр суралцаж буй оюутнуудад зөвлөгөө хүргэв.

“Миний мэргэжил-Миний амьдрал”




Зураг 3.1.4 2021.11.05

ЭХС-ийн ЭНЕРГЕТИК клубын намрын улирлын үйл ажиллагааны танхимаар зохиогдох ажлын эхлэл болсон "Миний мэргэжил-Миний амьдрал" сэдэвт Зангиагүй уулзалт буюу чөлөөт ярилцлагыг хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулав.

Энэхүү чөлөөт ярилцлагад өөрийн мэдлэг, туршлагаасаа оюутнуудтай маань чөлөөтэй хуваалцаж, ярилцахаар 2005 оны ДЦС-ын ангийн төгсөгч, ДЦС-4 ТӨХК-ийн зуухан цехийн техник, технологийн инженер Ч.Галиндэв, 2006 оны ДЦС-ын ангийн төгсөгч, ДҮТ-ийн Судалгаа, хөгжлийн албаны дарга Э.Ганбат инженерүүд ирж клубын жинхэнэ гишүүдтэй уулзаж яриа хийв. Тус ярилцлагыг клубын албан ёсны хуудасанд бүрэн хэмжээний бичлэг болгож байршуулсан.

“Манай эрдэмтэд” цуврал лекц



Зураг 3.2.1 2021.11.17

Монгол улсад шинэ үеийн Боловсролын салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ой, ЭХС-ийн 60 жилийн ойд зориулан "Манай Эрдэмтэд" цувралыг цаашид зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус цувралын хүрээнд манай дулааны инженерийн салбарын олон жилийн туршлагатай, нэр алдар бүхий эрдэмтэн судлаачид оролцох болно.

Анхны цувралыг МУ-ын гавьяат багш, ШУ-ны доктор, Академич С.Батмөнх " Эрчим хүч, түүний үйлдвэрлэлийн талаарх шинжлэх ухааны хөгжлийн тухай " сэдвээр 2021 оны 11-р сарын 17-ны өдөр танхимын дүүргэлт 10 гишүүдтэйгээр зохион, цахимаар (ZOOM апплейкшн) ашиглан шууд дамжуулсан. Мөн тус цувралыг бичлэг хэлбэрт оруулж (Youtube) хуудсанд дэмжигч, жинхэнэ гишүүдэд зориулан байршуулав. Жич: Тус клубын анги болох ЭХС-ийн 2-313 тоот анги нь цар тахлын улмаас 10-аас дээш оюутан суух боломжгүй болсон.

Клубийн дэмжигч гишүүдтэй хийсэн уулзалт



Зураг 3.2.1 2021.11.17

Д.Мандал багшийн 1970 онд удирдан төгсгөсөн анхны ангийн оюутан Цэсэд гуай болон ахмад төгсөгчдийн төлөөлөл бидэнтэй уулзаж клубын үйл ажиллагаатай танилцан, тус клубын номын санд өөрсдийн хандивыг өргөв.

Клубийн Вэб хуудас хөгжүүлэлт

Тус салбарын талаар танин мэдэхүйн мэдээллүүд тавих мөн төгсөж гарсан клубын гишүүдийг ажил олгогч нартай холбох зорилгоор "Software Solutions Company"/ DLP LLC хамтран тус клубын вэб хуудсыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр хийлгүүлэхээр тохиров. Тус вэб ашиглалтанд орсноор клубын нүүр хуудсанд байршуулдаг ажлын зарыг эмх цэгцтэй болгож, ажил олгогч, ажил горилогч нараас татаас авч клубын цаашдын төсвийг бүрдүүлэх боломжтой болно.

Үр дүн , дүгнэлт

2021-2022 оны хичээлийн жилийн намрын улиралд тус клубын үйл ажиллагааг цар тахалын нөхцөл байдалтай холбогдон танхимаар болон цахимаар уялдуулж зохион байгуулав. Мөн клубын нүүр номын хуудсаар дамжуулан удирдах багш нар зөвлөгөө, гишүүдийг чадавхижуулах мэдээлэл болон ажил олгогч байгууллагуудтай цаг алдалгүй холбон ажиллаж байсан. Мөн ZOOM, Microsoft teams платформуудыг ашиглан салбартаа тэргүүлэн ажиллаж буй инженерүүдийг удирдах багшаар дамжуулан урьж оролцуулж, лекц хэлэлцүүлгийг тасралтгүй зохион байгууллаа. Одоогоор тус клубын нүүр номын хуудас 764 гишүүнтэй байна.

Тус клубийн үйл ажиллагааны төлөвлөгөө цар тахалын нөхцөл байдалтай холбогдон анги дүүргэлт багатайгаар зохион байгуулагдсан хэдий ч лекц, ярилцлагуудыг бичлэг хэлбэрээр хадгалан подкаст хэлбэрт оруулж дараа дараагийн оюутануудад түгээх боломжийг бий болгосон. Цаашид манай клуб нөхцөл байдалтай уялдан цахим болон танхимийн үйл ажиллагаануудыг зохион байгуулж гишүүдийн идэвхи оролцоог нэмэгдүүлж, ажиллана.

“ЗВЁЗДОЧКА” КЛУБИЙН ТАЙЛАН

Танилцуулга

Звёздочка клуб нь ШУТИС-ийн ГХС-ийн Хэрэглээний хэл шинжлэлийн салбарын дор 2011 оны 9 сард байгуулагдсан бөгөөд 10 жилийн хугацаанд нийт оюутан залууст үнэ төлбөргүй шинжлэх ухааны англи, орос хэлийг зааж, сургадаг билээ. Клубийн зөвлөх багшаар ХХШС-ын ахлах багш М.Байгаль ажиллаж, клубийн ахлагч англи хэлний багшаар ГХС-ийн 4-р курсийн оюутан М.Самбууням, орос хэлний багшаар ГХС-ийн 1-р курсийн оюутан С.Тэлмэн нар тус тус ажиллаж байна. Нийт ажиллах хугацаандаа ШУТИС-ийн хэмжээнд гадаад хэл дээрх уралдаан тэмцээн зохион байгуулан оюутнуудыг идэвхжүүлж, хэлний хүнд хэлбэр болох шинжлэх ухааны гадаад хэл заадгаараа чухал онцлогтой билээ.

Клубийн зорилго

ШУТИС-ийн мэргэжлийн орос, англи хэлний “Звёздочка” клуб нь ШУТИС-д суралцаж байгаа нийт оюутан залуусд шинжлэх ухааны гадаад хэлний боловсрол олгох, соён гэгээрүүлэх, гадаад хэл сурах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд тухайн улсын соёл уламжлалыг танин мэдүүлэх, оюутан залуусын чөлөөт цагыг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн болно. Мөн оюутан залууст ОХУ-ын боловсрол, шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг сурталчилах зорилготой.

Чиглэл

1. Гадаад хүмүүстэй ярилцах (Native speaker)
2. Орос болон Англи хэл дээрх hot seller номнууд дээр гарч буй өгүүлбэрүүдийг сонгон авч, орчуулан ярилцаж, дүн шинжилгээ хийх.
3. Дуу, шүлэг цээжлэн үгсийн сангаа баяжуулах.
4. Клубын хичээлийн үеэр оюутанууд хоорондоо зөвхөн англи, орос хэл дээр харилцах.
5. Англи, орос кино үзэж тухайн улсын ярианы гол хэлц үгс болон ярианы хэлийг цээжлэх.
6. Дүрэм, яриа хослон хэлний мэдлэгээ дээшлүүлэх,
7. 7 хоног бүр түвшин тогтоох тест авах
8. Инженерийн чиглэлийн салбар бүрийн шинжлэх ухааны орчуулга хийх
9. Гадаад улсын онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, гадаад улсад боловсролын горилсон, хэл шинжлэлийн ухааны ахисан зэрэгтэй эрдэмтэн багш нартай ярилцлага хийж, сургалт семинарт түлхүү оролцуулах.

Клубийн гишүүд

2021-2022 оны хаврын улирлын хичээлийн жилд Звёздочка клубийн сургалтад нийт 56 оюутан хамрагдсан байна. Тухайлбал,

1. Англи хэл- **40** оюутан
2. Орос хэл- **16** оюутан тус тус хамрагдсан байна.


Англи хэлний сургалтад хамрагдсан оюутнуудыг салбар тус бүрээр ангилан үзвээс,

№	Салбар сургууль	Оюутны тоо
1	Барилга архитекторын сургууль	12
2	Гадаад хэлний сургууль	1
3	Бизнесийн, хүмүүнлэгийн ухааны сургууль	2
4	Эрчим хүчний сургууль	10
5	Геологи, уул уурхайн сургууль	13
6	Үйлдвэрлэл, технологийн сургууль	1
7	АШУҮИС	1
		Нийт: 40

Орос хэлний сургалтад хамрагдсан оюутнуудыг салбар тус бүрээр ангилан үзвээс,

№	Салбар сургууль	Оюутны тоо
1	Барилга, архитекторын сургууль	5
2	Гадаад хэлний сургууль	2
3	Эрчим хүчний сургууль	5
4	Геологи, уул уурхайн сургууль	4
		Нийт: 16

Англи хэлний сургалтад хамрагдсан оюутнуудыг курс тус бүрээр ангилан үзвээс,



Шинэ элсэлт

Клубийн элсэлт нийт үндсэн ба нэмэлт гэсэн 2 янзаар 2 удаа явагдсан бөгөөд нийт 128 оюутан бүртгүүлсэн байна. Цар тахал болон, анги танхимийн хүрэлцээнээс шалтгаалан ангид 40 оюутны квот байсан бөгөөд үндсэн элсэлтэд англи хэлний ангид 30 оюутан, нэмэлт элсэлтэд 10 оюутан авсан. Орос хэлний ангид нийт 16 оюутан элсүүлэн суралцуулсан болно.

Questions **Responses 67** Settings Total points: 0

67 responses + ⋮

Accepting responses

Summary Question Individual

Insights

Average 0 / 0 points	Median 0 / 0 points	Range 0 - 0 points
--------------------------------	-------------------------------	------------------------------

Questions **Responses 61** Settings Total points: 0

61 responses + ⋮

Accepting responses

Summary Question Individual

Insights



Клубийн хичээл

2021 оны 09 сарын 07-ны өдөр сургалтын чанарыг сайжруулах, чанартай боловсрол олгох зорилгоор хичээлийн хөтөлбөрийг боловсруулан ХХШС-ын эрхлэгч док., дэд профессор Ц.Цэцэгмаа багшаар хянуулан, ГХС-ийн багш нараас зөвлөгөө аван батлуулсан болно.

2021-2022 оны хичээлийн жилд манай клубийн хичээл англи, орос хэл 2 удаагийн оролттой, тус бүр 2 цагийн хуваарилалттай байсан боловч оюутнуудын хүсэлтээр долоо хоногт англи хэлний хичээлийг 2 удаагийн давтамжтай 2 цагийн хугацаатай зохион байгуулсан болно.

Сургалтын арга зүйн хувьд

- бүтэцчилсэн танилцуулга арга



сургалтын тонгоруу аргуудыг ашигласан болно.



Нийт 15 долоо хоног хичээллэсэн бөгөөд эхний 2 долоо хоног цахим хэлбэрээр үлдсэн 13 долоо хоног танхимийн хичээлээр явагдсан болно. Сургалтад хамрагдсан оюутнууд нийт үнэ төлбөргүй мэргэжлийн, шинжлэх ухааны англи, орос хэлний 60 цагийн хичээлд хамрагдсан байна.

Оюутнуудын ирц

2020-2021 оны хичээлийн жилтэй харьцуулахад 45 хувиар илүү байсан бөгөөд долоо хоног тус бүрээр ангилан үзвээс

1-р долоо хоног 100%


4-р долоо хоног 95%

8-р долоо хоног 85%



14-р долоо хоног 95%-ийн ирцтэй байснаас үзвэл сургалтын чанар сайжирч, оюутанд үр өгөөжтэй байсныг илтгэж байна.


КЛУБЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2021 оны 09-р сарын 20-ны өдөр англи хэлний академийн захирал, хэл шинжлэлийн ухааны док., дэд проф., З. Ганчимэгтэй ярилцан, үг зүйн дүрмийн хичээл заалгалаа.



Оюутны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой долоо хоног бүрийн амралтын өдрүүдэд “Зөв би” эвентүүдийг зохион байгуулсны нэг болох 10-р сарын 02-ны өдөр теннисээр хичээллээ.



2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын сургалтын гол зорилго англи хэлний хамгийн гол зүйл болох өгүүлбэр зүйн бүтэцийг задалж, шинжлэх ухааны орчуулга хийх байсан. Оюутнууд өөрт оноогдсон өгүүлбэрийг мөчлөх буюу задалж, дараа нь орчуулан анги хамт олондоо танилцуулж буй үе.


“Би зөв” аяны хүрээнд нийт клубийн гишүүд 10 сарын 10-ны өдөр заал авлаа.



Гадаад хэл сурах хүсэлтэй хүн бүр бие даан суралцах хэрэгтэй байдаг бөгөөд сургалтын тонгоруу аргыг ашиглан хичээл орохоос өмнө багш оюутнуудад даалгавар өгч, хичээлийн цаг дээр амаар асуулга авч байгаа үе.



Тонгоруу аргын нэг хэлбэр болох гадаад хэлний харилцан яриаг урьдаас цээжлэн, хичээл дээр клубийн нийт гишүүн бүртээ ярилцаж байгаа үе.



10-р сарын 20-ны өдөр “Урам зориг түгээе” аяныг зохион байгуулж, ШУТИС-ийн 8 салбар сургуулийг татан оролцуулан оюутнуудыг чин сэтгэлийн үгийг түгээсэн бөгөөд манай үйл ажиллагаа нийт 50 мянган хүнд хүрч чадсан байлаа.



10-р сарын 24-ны өдөр “Зөв би” аяны хүрээнд хийгдсэн дараагийн нэг ажил болох богд ууланд клубийн нийт гишүүдийн хамт аялаж ,цэвэр агаарт гарлаа.

Хичээл тус бүрийн эхэнд клубийн сүлд дуу болох “This land is your land” дууг хамтдаа дуулан эхлүүлдэг билээ.



Оюутнуудыг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах зорилготойгоор хичээлийн 2 цагийн сүүлийн 30 минутыг сэтгэцийн эрүүл мэнд болон хөгжөөнт байдлын хэсэг болгон хөтөлбөрт оруулсан. Энэ үед оюутнууд дугуй ширээний ярилцлага хийн өөрт

тулгамдаж байгаа асуудлуудыг бусадтайгаа ярилцан зөвлөлдөж, сэтгэлээ тайтгаруулдаг билээ. Мөн түүнчлэн оюутан насыг дурсамж дүүрэн өнгөрөөхийн тулд дуулж, хуурдлаа.



Тус зураг дээр байгаа “Our dream” нэртэй биелүүлэхийг хүссэн хүслүүдээ бичсэн бөгөөд “Би зөв” аяны хүрээнд боломжтой зүйлсийг хэрэгжүүлсэн болно. 11-р сарын 09-ны өдөр клубийн гишүүд тус бүр англи хэлний байц, тодотгол, тусгагдахуун өгүүлбэрүүдээс сонгон авч, жишээ өгүүлбэрийн хамт ангийхандаа тайлбарлаж өглөө.



11-р сарын 10-ны өдөр англи хэлний, сонсгол дуудлага сайжруулах зорилготой кино өдөрлөг зохион байгууллаа.





11-р сарын 12-ны өдөр ГХЯ-ны төрийн дээд түвшний орчуулагч нартай “Хэл сурах арга зөвлөмж”-ийн талаар уулзалт, ярилцлага хийлээ.



МОНГОЛ-ОРОСЫН найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд ШУТИС-ийн Звёздочка клубээс жил бүр уламжлал болгон ШУТИС-ийн хэмжээнд гадаад хэл дээр зохион байгуулдаг ээлжит уралдаанаа зарласан билээ.

1. "Всемирный пушкин" шүлгийн уралдаан
2. "Моя родина Монголия" постер илтгэлийн уралдаан
3. "Нoug" сэдэвт богино хэмжээний видео контентийн уралдааныг тус тус зохион байгуулсан болно. Шагналыг нэгдсэн журмаар гардуулсан бөгөөд шагналт байранд шалгарсан оюутнуудыг дор дурдсан болно.



Оюутнууд сургалтад маш их зүйл сурч мэдсэн сэтгэгдлээ багшийнхаа төрсөн өдрөөр одоо үед ховордсон ил захидалаар илэрхийлсэн билээ.



Хэн сайн үг цээжлэх вэ? сэдэвт С2 түвшиний 100 үг цээжлэх АХА тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа.

- 🥇 1-р байр БАС-ийн оюутан Г.Энэрэл /В211350028/
- 🥈 2-р байр ГУУС-ийн оюутан П.Пэлжээ /В201930025/
- 🥉 3-р байр ГУУС-ийн оюутан Ц.Оюунбилэг /В211280029/





Хэл сурч байгаа хүмүүс гадаад ч бай эх хэлээ бичгийн болон ярианы хэлэнд хоёуланд нь төгс эзэмших шаардлагатай байдаг билээ. Бид тэгвэл амаар гардаггүй сэтгэлийн үгсээ бие биеэндээ бичгийн хэлээр дамжуулж, нийт гишүүддээ урам зориг огч, хайр түгээх “Зөв би” аяны ээлжит ажлаа 11 сарын 22-ны өдөр зохион байгууллаа.




ШУТИС-ИЙН ЗВЁЗДОЧКА КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТАНИЛЦУУЛАХ ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ШУТИС-ийн мэргэжлийн орос, англи хэлний Звёздочка клуб нь нийт оюутан залуустаа инженерийн, шинжлэх ухааны англи, орос хэл заадгаараа онцлогтой билээ. Тэгвэл клубийн нэг өдрийн хичээл хэрхэн явагддаг талаар танилцуулах, сургалтын чанар тогтоох зорилготой гадаад хэлний сургуулийн захирал, эрхлэгч,

багш нарыг 2021 оны 11 сарын 23-ны өдөр ШУТИС-ийн номын сангийн Русский центрт урьж оролцууллаа. Уригдсан захирал, эрхлэгч, багш нарт клубийн багш М.Самбууням шинжлэх ухааны орчуулгын хичээл орсон бөгөөд хүрэлцэн ирсэн багш, ажилчид

- сургалтын хөтөлбөрт 10-8 оноо,
- сургалтын чанарт 10-7 оноо,
- клубийн үйл ажиллагаанд 10-9 оноогоор тус тус дүгнэлээ.

 ШУТИС, ГХС-ийн ХХШС-ын харьяа Звёздочка клуб нь ШУТИС-ийн мэргэжлийн орос, англи хэлний клуб юм.



 5,753 хүн үүнийг таалах

 5,990 хүн дагаж байна

 <http://fli.edu.mn/mn/page/494>



Клубийн гишүүдийн авъяас чадварыг нээх зорилготой 30 минутын хүрээнд гишүүд дуулж, хөгжим тоглож өнгөрөөдөг бөгөөд бичлэг тус бүрийг клубийн фэйсбүүк хуудаст байрлуулдаг билээ. Одоогийн байдлаар манай хуудас **5753** таалагдлаа, **5990** дагагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд гишүүдийн бичлэгүүд нийт **268.473** хүнд хүрч, **3257** хариу үйлдэл авсан байна. Тухайлбал,



ШУТИС, Звёздочка клуб
Арван нэгдүгээр сарын 24-нд 15:50 цагт

Дуучин Энэрэл chihigo дууны гайхалтай коверийг хийсэн шүү дээ. Тэгвэл бид хэд амьдаар сонордлоо. 😊...

Цааш үзэх

3.1M 8 сэтгэгдэл 198M удаа үзжээ

263.5M Сурталчилгаа хүрсэн хүний тоо	3.6M Reactions, comments, and shares
198.9M 3 секунд бичлэг үзсэн тоо	Retention curve

View more video details

Таалагдлаа Сэтгэгдэл Хуваалцах

Клубийн гишүүн БАС-ийн оюутан Г.Энэрэлийн бичлэг 263.500 хүнд хүрч, 3.100 лайк авсанаар ШУТИС-аар овоглосон дахин нэг дуучин мэндэлсэнд тооцож болох билээ.

Бичлэгийг үзэхийг хүсвэл:

<https://www.facebook.com/Zwyozdochka10/videos/1032547793956137/> хандаарай.



КЛУБИЙН НИЙТ ГИШҮҮД УНГАР УЛСЫН ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ОБРУШАНСКИЙ БОРБАЛА АННАТАЙ УУЛЗЛАА


Клубийн нийт гишүүд 12-р сарын 06-ны өдөр Унгар улсын элчин сайд Обрушанский Борбала Аннатай уулзалт хийж, Унгар улсын засгын газрын талаар ярилцлага хийлээ. Клубийн нийт гишүүд гадаадад сурах сонирхолтой бөгөөд засгийн газрын тэтгэлгийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл авч чадсан билээ.






12-р сарын 07-ны өдөр клубийн сүүлчиний хичээл орж, оюутнуудаас түвшин тогтоох шалгалт авлаа. Бүх түвшний оюутнуудад хичээл ордог бөгөөд эхний хичээл дээр анхан шатны мэдлэгтэй оюутнууд А2 түвшин. А2 түвшний оюутнууд В1, В2 түвшин, В1, В2 түвшинтэй оюутнууд С1 түвшин рүү ахисан байсан нь тогтоогдлоо. Ийнхүү сургалтын хөтөлбөр, чанар шинчлэгдсэний үр дүнд оюутнуудын гадаад хэлний мэдлэг дор хаяж нэг түвшин нэмэгдсэн нь харагдаж байгаад туйлын их баяртай байна.

ТӨГСГӨЛ ХИЧЭЭЛД ОЮУТНУУД ӨӨРСДИЙН СЭТГЭГДЛЭЭ ӨРГӨДӨЛ БОЛГОН КЛУБТЭЭ БИЧЛЭЭ





ЭРЭХ СЭТГЭГДЛЭЭС ХАРВААС КЛУБИЙН ХИЧЭЭЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА ТУЙЛЫН ӨНДӨР БАЙГААГ ХАРУУЛЖ БАЙНА.



КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХААЖ, НЭГДСЭН ЖУРМААР ТЭМЦЭЭН УРАЛДААНД БАЙР ЭЗЭЛСЭН ОЮУТАНУУД, БОЛОН АМЖИЛТТАЙ НЭГ СЕМЕСТРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОРЧУУЛГА, АНГЛИ ХЭЛНИЙ ӨГҮҮЛБЭР ЗҮЙН 60 ЦАГИЙН КУРСИЙГ ДҮҮРГЭСЭН ОЮУТНУУДДАА БАТЛАМЖ ГАРДУУЛЛАА.



Шагнал 1. 2020-2021 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд зохион байгуулагдсан “Миний дуулах дуртай гадаад дуу” уралдааны шагнал

3-р байр Барилга архитекторын сургуулийн оюутан Мөнхжаргалын Дорждагва

2-р байр Геологи уул, уурхайн сургуулийн оюутан Э.Амарбаяр

1-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Б.Мөнгөнтуяа

Шагнал 2. Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд ХХШС-аас зохион байгуулсан “Всемирный Пушкин” шүлгийн уралдааны шагнал

3-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Сонинхишигийн Тэлмэн

2-р байр Эрчим хүчний сургуулийн оюутан Э.Хулан

1-р байр Мэдээлэл, холбоо технологийн сургуулийн оюутан Б.Биндэръяа

Шагнал 3. Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд ХХШС-аас зохион байгуулсан “Моя родина моя монголия” постер илтгэлийн шагнал

3-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Сонинхишигийн Тэлмэн
2-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Д. Мөнхчулуун
1-р байр Мэдээлэл, холбоо технологийн сургуулийн оюутан С.Амарзаяа

Шагнал 4. Монгол-Оросын найрамдал, хамтын ажиллагааны өдрүүдийн хүрээнд ХХШС-аас зохион байгуулсан “HOUR” сэдэвт богино хэмжээний видео контентийн шагнал

3-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Ц.Намуундарь, Э.Дагийранз
2-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Э.Энхтуяа, Б.Буянбилэг, Б.Сайнбуян
1-р байр Гадаад хэлний сургуулийн оюутан Сүхбаатарын Пүрэвэрдэнэ


Шагнал 5. ШУТИС-ийн мэргэжлийн орос, англи хэлний Звёздочка клубийн 1 семестрийн англи хэлний өгүүлбэр зүйн болон, шинжлэх ухааны орчуулгын курсд өөрийн хичээл зүтгэл, ур ухаанаа уралдуулан манлайлсан шинэ эриний шилдэг түүчээ болсон оюутан залуус олон байна.

Шагнал 6. Гадаад хэлний сургуулийн захирлын зөвлөл Звёздочка клубийн ахлагч, англи хэлний багш М.Самбуунямд батламж гардуулав.

Тэрээр ШУТИС-д суралцах хугацаандаа Гадаад хэлний сургуулийн манлайлагч оюутан, Англи хэлний олимпиадын 1-р байр, Голомт банкны шилдэг 100 оюутны тэтгэлэг, ШУТИС-ийн шарк, ШУТИС-ийн орон орны хэл дээрх илтгэлийн уралдаан 1-р байр, Заг группын 30 жилийн ойн хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал 1-р байр зэрэг олон амжилтыг гаргасны сацуу нийт ШУТИС-ийн 300 гаруй оюутан залууст үнэ төлбөргүй шинжлэх ухааны англи хэлний мэдлэг олгосон манлайлагч оюутан юм.



ДҮГНЭЛТ



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2021-2022 оны хаврын улирлын хичээлийн жил “Звёздочка” клуб нь оюутнуудын сурч хөгжих, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, англи, орос хэлний өгүүлбэр зүй, шинжлэх ухааны орчуулга хийх үндсэн зорилго тавьсан ба уг зорилгодоо хүрэхийн тулд нийт 20 үйл ажиллагаа, 4 тэмцээн уралдаан зохион байгуулсан байна. Үйл ажиллагаа маань нийт давхардсан тоогоор 260.000 хүнд хүрч, 3700 хандалт авснаараа онцлогтой жил болж өнгөрлөө.

Үүнээс гадна хичээлийн шинэчилсэн хөтөлбөр батлуулж, сургалтын чанарыг өндөр дээд түвшинд хүргэх зорилгоор гадаад хэл шинжлэлийн ухааны ахисан түвшний мэргэжилтнүүдтэй уулзалт зөвлөгөө авч, хичээлийн агуулгаа сайжруулсан ба сүүлийн

хичээл дээр placement test буюу түвшин тогтоох шалгалт авсан билээ. Шалгалтын хариуд амжилттай суралцсан 30 оюутан 100 хувь түвшин дээшилсэн тогтоогдсон.

Шинжлэх ухааны орос, англи хэлийг мэргэжлийн түвшинд ШУТИС-иас өөр газар заадаггүй бөгөөд манай клуб үнэ төлбөргүй инженерийн ангийн оюутнуудад зааж, сургасан нь маш том хүмүүнлэгийн ажил, амжилтад тооцогдох билээ.

Ийнхүү амжилттай суралцсан, уралдаан тэмцээнд шагналт байр эзэлсэн нийт оюутнууддаа шагнал гардуулах ёслолоор нэгдсэн журмаар шагналуудыг гардуулж, амжилттай клубийн намрын улирлын үйл ажиллагааг хаасан билээ.

Эдгээр үйл ажиллагааг удирдан чиглүүлсэн клубийн зөвлөх багш М.Байгаль болон клубийн ахлагч, англи хэлний багш М.Самбууням нарт талархсан сэтгэгдлээ илэрхийлье.

Клубын тэргүүн: В180420226 М. Самбууням (ГХС-ийн оюутан)

Кредитын урамшуулал авах гишүүн: В210420041 С. Тэлмэн (ГХС-ийн оюутан, клубийн орос хэлний багш)

Клубийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг:

<https://www.facebook.com/Zwozdochka10>

ШУТИС-ИЙН САЙН ДУРЫН КЛУБУУДИЙН ТАЙЛАН


“EMPOWERMENT” КЛУБИЙН ТАЙЛАН

Клубийн зорилго:

Их сургуулийн мэдлэгийг олж суралцаж байх хугацаандаа, оюутан залуусын чөлөөт цагаа зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэхэд туслан, илтгэх урлаг, парламентийн мэтгэлцээнийг эзэмшүүлэх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, оновчтой шийдвэр гаргах олон нийтийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой харилцаанд өөрийгөө дасгаж, нээн хувь хүний ёс зүйтэй, харилцааны соёл, болон бусдыг удирдан зохион байгуулах үйл ажиллагаанд суралцах, шинийг эрэлхийлэх, судлахад оршино.

Товч танилцуулга:

- Байгуулсан огноо: 2011 он
- Хамрах хүрээ: Мэтгэлцээн, уран илтгэлийн чиглэл
- Багш : Ч.Сайхнаа
- Гишүүнчлэл - 27 эмэгтэй, 34 эрэгтэй



Клубийн дотоод үйл ажиллагаанд чиглэсэн ажил:

- * Тогтмол зохион байгуулдаг уулзалт;
- * Өдөр тутмын бэлтгэл;
- * Гишүүдийг идэвхжүүлэх зорилготой үйл ажиллагаа;
 - Кино хэлэлцүүлэг;

- Номын хэлэлцүүлэг;
- Клубийн дотоод тэмцээн;
- Клубээс гадуур зохион байгуулсан тэмцээн;
- Онлайн сургалт

Нэгдсэн үйл ажиллагаанд оролцсон байдал:

- * Клубүүдийн нээлттэй өдөрлөг
- * Empowermet клубийн явган аялал;
- * Клубүүдийн нэгдсэн сайн үйлсийн аян

Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа:

/Дэлгэрэнгүй/

Клубийн дотоод үйл ажиллагаа:

Долоо хоног бүрд хоёр удаа ордог

Пүрэв 18:00-21:00 Илтгэл\ TV-заал

Баасан 18:00-21:00 Мэтгэлцээн\ TV-заал



Танилцуулга хичээл:

Оролцсон оюутны тоо: 61
2021 оны 10 сарын 14, 15

2020 оны 11дүгээр сарын 27 нд парламентын мэтгэлцээний SNITCH клубээс 1-р түвшний оюутнуудын дунд зохион байгуулж буй "НЭГИЙН ДАВАА" парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээн
Оролцсон гишүүд \4\



2020 оны 11 сарын 27 -ны өдөр “Нийгмийн витаминжуулалт улсын Илтгэх ур чадварын тэмцээн”-д амжилттай оролцон Empowerment клубийн ахлагч Х.Оюунтүлхүүр тэргүүн байр empowerment клубийн гишүүн Н.Бат-Ирээдүй гутгаар байрт шалгарсан.

Оролцсон гишүүд \2\



2021.12.11ээс -12ны өдрүүдэд зохион байгуулсан "Оюутны Оюуны Давалгаа - IV" улсын аварга шалгаруулах уран илтгэлийн тэмцээнд Empowerment клубийн гишүүн О.Билгүүн тэргүүн байр эзэлсэн ба улсын аварга илтгэгч боллоо.



2021 оны 12 сарын 02 нд Empowerment клубийн гишүүдийн дунд 3 минутын уран илтгэлийн тэмцээн зохион байгуулсан.

- Тэргүүн байр: Empowerment клубийн гишүүн Н.Бат-Ирээдүй
- Дэд байр: Empowerment клубийн гишүүн Г.Ууганжаргал тус тус амжилт гаргасан.



ШУТИС-ийн science fm 94.1 радиод empowerment клубийн гишүүд радио хөтлөгчөөр суралцан ажиллаж байгаа.

Хамрагдсан оюутан /2/



Нийслэлийн 33-р сургуулийн дунд ангийн суралцагч нарт 2021.10 сард Empowerment клубийн гишүүд “Тархины код”, “Бүтээмжтэй хүн” сэдвүүдээр сургалт орсон.





Кино ба номын хэлэлцүүлэг 2021.12.09нд Харизм номын хэлэлцүүлэг болж клубийн гишүүд амжилттай хамрагдсан.



Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны оролцоо идэвх /товч/ Танд тусалъя аян

Оролцсон оюутны тоо \11\
2021 оны 09 сарын 13 -17 нд



Сайн үйлсийн аян /SaveMunkhuu/

Оролцсон оюутны тоо \15\

2021 оны 12 сарын 08 -10 нд

ШУТИС-ын Цахилгаан электротехникийн инженер мэргэжлээр суралцаж байгаа төгсөх курсийн оюутан Д.Эрдэнэмох 21 нарийн, шулуун гэдэсний хорт хавдартай, элгэндээ үсэрхийлсэн гэсэн харамсалтай оношоор эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул ШУТИС-ийн Empowerment клубийн хамт олон энэхүү аянд нэгдсэн.



Үр дүн:

- Empowerment клуб нь TV-заалд хичээллэн тайзны соёл индэртэй хэрхэн харьцах гэх мэтчилэн дотоод үйл ажиллагаанд хэд хэдэн шинэчлэлт хийснээр урьд өмнөхөөсөө илүү үр дүнтэй болсон. Клубийн гишүүдийн үзүүлсэн амжилт, ахиц урьд өмнөхөөсөө илүү сайжирсан. Жишээ дурдвал. Монгол улсын хэмжээнд зохион байгуулагддаг уран илтгэлийн тэмцээнд тэргүүн байр. Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Нийгмийн витаминжуулалт” илтгэлийн тэмцээнд “Тэргүүн”, “Гутгаар” байрын амжилтуудыг Илтгэх урлагийн хэмжээнд гаргасан.
- Хувь хүний хөгжил ба ур чадвараа дээшлүүлэх сургалтанд хамрагдсан /3/
- Нийслэлийн 33-р сургуультай хамтран Хувь хүний хөгжлийн сургалтуудыг орсон.

Дүгнэлт

- Empowerment клуб нь клубийн байнгийн үйл ажиллагааг хангах зорилгодоо хүрч идэвхтэн гишүүдийг нэмэгдүүлж гишүүдийн чадварыг хөгжүүлэн тэмцээн уралдаанд маш амжилттайгаар оролцсон.

“БАГШИЙН ТУСЛАХ ОЮУТАН” КЛУБИЙН ТАЙЛАН


Товч танилцуулга

Зорилго: ШУТИС-ийн оюутнуудын хичээлийн хоцрогдол арилгах, тэднийг дэмжих болон мэдлэгийн түвшинг ахиулах, хувь хүний хөгжил манлайлах чадвар, арван жилийн дүү нартаа өөрийн сургуулиа суртчилах, давуу талуудыг таниулахад оршино.

Үйл ажиллагааны чиглэл: Манай клуб нь оюутнуудын хичээлийн хоцрогдлыг арилгах, шалгалтанд нь амжилттай бэлтгэх зорилгоор 4-5 хичээлээр оюутнуудад оюутан багшаар дамжуулж хичээл ордог ба энэ нь тэдэнд ахиц дэвшил гаргах, амжилттай сурахад нь түлхэц болж өгдөг. Бүрэн дунд сургуулийн хүүхдүүд ЭЕШ-ийн айдасыг даван туулах мэргэжилээ хэрхэн зөв сонгох, Монгол Улсад суралцах давуу талууд дотоодын тэтгэлэгт хөтөлбөрүүдийг таниулахад оршино.

Гишүүнчлэл: Нийт 10 гишүүн-4эрэгтэй, 6-эмэгтэй

Сүүлийн 2 семестрийн гишүүнчлэл





Хийж гүйцэтгэсэн ажил


- Клубийн зохион байгуулсан дотоод үйл ажиллагаа
- Клубуудын нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо идэвхитэй сэтгэл
- Бүрэн дунд сургуулийн хүүхдүүд ЭЕШ-ийн айдасыг даван туулах, мэргэжил сонголт, завсар жил авах давуу талууд болон сул талууд, оюутан багш нар болон ахлагч тус бүр өөр өөрийн гэсэн онцлого, мэргэжил сонголт хэрхэн мэргэн сонгосон юунд нь дуралдаг талаар хэлэлцүүлэг
- Клубуудын удирдлагыг хэрхэн зөв, хүртээмжтэй байлгах сургалт
- Баг хамт олноороо чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх
- Давтлага хичээлүүдийг 3 удаа хүртээмжтэй байлгах
- Хичээлүүдийг сонирхолтой байдлаар хүргэн хоцрогдол арилган манлайлал бүхий оюутанг бэлтгэн гаргах

Хичээлийн хоцрогдол арилгах төлөвлөгөөт хичээлүүд

Бид энэ намрын улиралд Математик-1(S.MT101),Физик-1(S.PH101), Ерөнхий хими(S.CT101), Дүрслэх геометр(S.ED101), Харилцааны Англи хэл(S.CE102),Ердийн дифференциал тэгшитгэл(S.MT202) гэсэн хичээлүүдээр оюутнуудын хичээлийн хоцрогдлыг арилгах тэднийг шалгалтанд нь амжилттай бэлтгэх зорилгоор VI-р 7 хоногоос эхлэн 7 хоног бүр хичээл тус бүр цар тахал гарсантай холбогдуулан Teams-ээр тодорхой хуваарийн дагуу 1 парын хугацаатай заагдсан. Нийт энэ улирал давхардсан тоогоор 2960 оюутан энэхүү хичээлд хамрагдсан.



Хичээлүүдийн ирцийг харьцуулсан график



1. 30 онооны зорилтот хичээл

Оюутнуудын 30 онооны шалгалтанд бэлдэх зорилгоор “30 онооны зорилтот” хичээлийг Математик-1(S.MT101),Физик-1(S.PH101), Ерөнхий хими(S.CT101), Дүрслэх геометр(S.ED101), Харилцааны Англи хэл(S.CE102),Ердийн дифференциал тэгшитгэл(S.MT202) гэсэн хичээлүүдээр гэсэн хичээлүүдээр 14 долоо хоног болон 15,16 хагсайн өдөр бүр зөвлөх багш нарын хамтаар чанартай, өгөөжтэй мэдлэгийг олгосон билээ.

Зураг 5. 30 онооны зорилтот хичээлийн хуваарь

ХШ бямба гарагийн 30 онооны шалгалтанд бэлтгэх хуваарь			
Зөвлөх Багш	Оюутан	Давтлаганы хуваарь	Оюутан багш утас
Г.Батцэцэг	Г.Хангал	19:30-20:30	99545050
Б.Одонтуяа	Б.Ану	16:00-17:00	99340808
М.Даваажав	Б.Од	18:30-19:30	88070237
Г.Батцэцэг	М.Нандин-эрдэнэ	10:00-11:00	96458008
Р.Долгоржав	Г.Бүрэнтогтох	13:00-14:00	89181090
М.Энхцэцэг	С.Ариунтунгалаг	19:30-20:30	96390949
Х.Дамчаасүрэн	Д.Энхбаяр	17:00-18:00	94320322
М.Нямдолгор	Ц.Биндэрьяа	11:30-12:30	88299218
Х.Дамчаасүрэн	Ш.Сугар-од	17:00-18:00	88214426

Клубийн уулзалт

Бид 7 хоног бүрийн Баасан гарагт 13:00 цагт 1-404-д болон цахим хаягаар хуралаа тогтмол хийсэн.Оюутан багш нар маань маш идэвхи, санаачлагатай оролцдог бөгөөд бид хурал хийх бүртэй нэг шинэ санаа, санаачлагыг олж, цаашид юу хийх, яаж ажиллах талаар ярилцаж үнэлэлт дүгнэлт хийдэг байсан.Энэ үйл ажиллагаа нь маш чухал бөгөөд бусдыг хөгжүүлэхээс гадна **өөрсдийгөө алхам тутамдаа хөгжүүлэх** хэрэгтэй.

Зураг 6. Бидний оюутнуудад зориулан хийсэн самбар.



Зураг 6.Багийн гишүүдийн уулзалт баг бүрэлдэхүүн



Бүрэн дунд сургуулийн мэргэжил сонголт болон видео



2. Мэдлэгээ хуваалцая аян

Мөнхтогтох Нандин-эрдэнэ	B210590008	ВЮ03311946
Сонинбаатар Ариунтунгалаг	B211020052	ЕЭ03292205
Гаваасүрэн Бүрэнтогтох	B180980120	ИЭ01280235
Батзориг Ану	B201360008	УК02270522
Одбаяр Сансармаа	B201360009	УЖ02212321
Ц.Биндэръяа	B211070075,	
Ш.Сугар-од-	B211050094,	
Д.Энхбаяр-	B201060004,	
Б.Од-	B211340013,	
Г.Хангал-	B191350944.	



Бид өөрсдийн мэргэжлийн онцлог болон цар тахалтай холбоотой энэ үед хэрхэн элсэлтийн ерөнхий шалгалтыг өөртөө дарамтгүйгээр даван туулах, зааж буй хичээлүүдээ хэрхэн хурдан амархан сурсан нууц, завсар жилийн давуу тал болон сул тал, өөрсдийн туршилга амжилтын түүх, оюутан болох мөн Монгол Улс тэр дундаа ШУТИС-д суралцах ямар гайхамшигтай, тэтгэлэг хэрхэн авах талаар хуваалцсан өдөрлөг болж өндөрлөсөн.Цахим системд шилжсэн энэ цаг хугацаанд сургуулиуд маань халдварын дэглэмээ барин хүсэлтийг цуцалсан боловч ӨЗБАС сургууль маань дэмжин тусалсаны үр дүнд бичлэг хийнэ сургуулиудийн цахим хуудаснаа толилуулан өгвөл зөвхөн төгсөх анги гэлтгүй залгамж дүү нарт минь том тус болох юм.

Клубийн танилцуулга хичээлийн агуулга

Намрын улирлын хичээлүүд маань цахим хэлбэрээр орсон тул оюутан нарын хамрагдах хүрээ даган чөлөөтэй өссөн бөгөөд ямар нэгэн айдасгүй мэдэхгүй гэх бодлыг өөрөөсөө холдуулан аливаад зөв боловсон харилцдаг, үргэлж өсөн дэвшидэг байдлаар хамтдаа зөвхөн хичээлийн хоцрогдол гэлтгүй ирээдүйн төлөө нэг ч гэсэн алхам хийж чадсан гэж тодорхойлж байна.



Зураг 9. Математик 1 хичээлийн явц



Зураг 10. Дүрслэх геометр хичээлийн явц


Зураг 11. Ерөнхий хими хичээлийн явц



Зураг 12. Харилцааны англи хэл хичээлийн явц

Цахим хичээлийн ирц хөтлөлт болон оролцоо

Оюутан багш нар маань хичээлийн тайланг долоо хоног бүр идэвхтэй явуулан хэрхэн хичээлээ сонирхолтой үр бүтээлтэй орох талаар хэлэлцдэг байсан ба хичээлийн ирц, хичээлийн бэлтгэл, ашигласан цахим хаяг болон өөрсдийн санааг тайландаа нэгтгэж явуулдаг, сургуулийн цахим хаягт үргэлж өөрийн хичээлийн зараа оруулан бусдын төлөө чин сэтгэлтэй мундаг оюутануудтай хамтарч ажилсандаа баяртай байна.



Зураг 13. Оюутан багш бүр багтаа

YPFull Name	User	Action	Timestamp	
Buranningkhin Gavaasuren	Joined	11/23/2021	11:01:49 PM	
B211170002 - Namuun Sumiya	Joined	11/23/2021	1:11:41 PM	
B211170022 - Namuun Sumiya	Left	11/23/2021	1:19:28 PM	
B211170022 - Namuun Sumiya	Joined	11/23/2021	1:19:35 PM	
B181270072 - Galbadrakh Nomyn Erdene	Joined	11/23/2021	1:12:20 PM	
B181270072 - Galbadrakh Nomyn Erdene	Left	11/23/2021	1:12:32 PM	
B211930025 - Galbadrakh Bumbayar	Joined	11/23/2021	1:14:30 PM	
B211930025 - Galbadrakh Bumbayar	Left	11/23/2021	1:14:48 PM	
B211930025 - Galbadrakh Bumbayar	Joined	11/23/2021	1:14:51 PM	
B211930025 - Galbadrakh Bumbayar	Left	11/23/2021	1:15:03 PM	
B211300036 - Tuguldurjav Arunbold	Joined	11/23/2021	1:14:12 PM	
B211300036 - Tuguldurjav Arunbold	Left	11/23/2021	1:15:33 PM	
B211350125 - Badamjav Tsevegmid	Joined	11/23/2021	1:14:23 PM	
B211350125 - Badamjav Tsevegmid	Left	11/23/2021	1:14:43 PM	
B211350125 - Badamjav Tsevegmid	Joined	11/23/2021	1:15:20 PM	
B211350125 - Badamjav Tsevegmid	Left	11/23/2021	1:16:42 PM	
B211100249 - Batsaikhan Myagmar-Erdene	Joined	11/23/2021	1:14:30 PM	
B211100249 - Batsaikhan Myagmar-Erdene	Left	11/23/2021	1:15:30 PM	
B201050672 - Unvalbat Balbaatar	Joined	11/23/2021	1:15:49 PM	
B201050672 - Unvalbat Balbaatar	Left	11/23/2021	1:15:58 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Joined	11/23/2021	1:15:57 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Left	11/23/2021	1:24:23 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Joined	11/23/2021	1:24:56 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Left	11/23/2021	1:24:58 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Joined	11/23/2021	1:25:09 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Left	11/23/2021	1:37:17 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Joined	11/23/2021	1:38:01 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Left	11/23/2021	1:38:14 PM	
B211170010 - Purevsuren Lkhagvasuren	Joined	11/23/2021	1:38:18 PM	
B211270007 - Regenushree Umadshtshiev	Joined	11/23/2021	1:15:08 PM	

Зураг 14. Хичээлийн явцын ирц 400-500 оюутантай

ДҮГНЭЛТ

Бидний энэ семестрийн үйл ажиллагаа маань амжилттай болж дууслаа. Энэ улирал клубийн дотооддоо зохион байгуулсан 2 үйл ажиллагаа, клубуудын нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагаа 4-ийг хамтран зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагаануудад маань давхардсан тоогоор нийт ШУТИС-ийн 1127 оюутан хамрагдав.

Намрын улиралын онцлох зүйл маань нийслэлийн БГД-ийн ЕБС-ийн ахлах ангийн нийт сурагчдад ЭЕШ-ын давтлага өгөх үйл ажиллагаа байв. Нийт энэ семестрийн зохион байгуулсан оролцсон үйл ажиллагаануудаа дүгнэхэд зарим зүйл дээр дутмаг зүйл байгаа хэдийч өмнөх улиралуудтайгаа харьцуулахад шинэ санаа, санаачлага ихтэйгээс гадна клубийн дотоод уур амьсгал, хийсэн бүтээсэн зүйл ихтэй байв.

Ирэх хаврын улирал хийж буй үйл ажиллагаануудынхаа чанар дээр анхаарч, өмнө алдсан зүйлс дээрээ үнэлэлт дүгнэлт хийж шийдэлд хүрч ажиллах болно. Удирдан чиглүүлэх хурал цугалаанд идэвхтэй суралцсан ба клубын үйл ажиллагаа цар тахалтай холбогдуулан олуулаа цуглахаас ихлүүлээд олон саадтай тулгарсан ч бид хамтдаа даван туулан тодорхой хэмжээний амжилтанд хүрч чадсан.

Олон нийтэд эрдэм мэдлэгийг түгээхээс гадна бие даан суралцах, хэрхэн тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэх гал халуун амьдралын нэгээхэн чухал оюутан насаа зөв хүрээлэл дунд манлайлагч хандах, зорилгоо үр бүтээлтэй тодорхойлж өдөр бүрийг аз жаргалтайгаар бусдын үгийг хүндэтгэн сонсох, өөрийн гэсэн үзэл бодолтой байх, уулзалт хуралын боловсроос эхлүүлээд ирээдүйд хэрэгтэй олон талын мэдлэгийг бид бүтээлээ.

“MUST COMEDY” клубийн тайлан

MUST comedy клуб нь анх 2019 оны 9 сард үүсгэн байгуулагдсан бөгөөд анх зургаан гишүүнтэй эхлүүлж байсан. Корона вируст халдварын /Ковид19/ улмаас 2020-2021 онуудад үйл ажиллагаа түр зогсоосон. 2021 оны 9 сарын 22-с эхлэн 130 гаруй шинэ гишүүн элсүүлэн үйл ажиллагаагаа эрчимжүүлсэн. MUST comedy клуб нь одоо 22 үндсэн гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

MUST comedy клуб нь элсэн орсон гишүүдээ хөгжилтэй, амьдралын зөв хэмнэлтэй, нийгмийн стрессээс хол, бүтээлч сэтгэлгээтэй, наргианч өөрийнхөөрөө байх боломж олгодог. Манай клуб найрсаг хамт олон, комеди урлагт хайртай, мэргэжилийн комедиануудыг бэлтгэх зорилготой төдийгүй. UB comedy, Comedy lab, Clap comedy шиг мэргэжилийн комеди клуб болох зорилт тавин ажиллаж байна.

“ MUST COMEDY КЛУБ” –ЫН 2021 ОНЫ НАМРЫН УЛИРЛЫН ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Зорилго	Зохион байгуулагч	Хэзээ
1.	MUST comedy клубын “Танилцуулга хичээл”	MUST comedy клубын зорилго, хичээлийг клубын шинэ гишүүдэд танилцуулах	Клубын дэд ахлагч, Баяраа(UB comedy, comedian)	IX/29
2.	Campus буяны байгуулагад тоглолт зохион байгуулах (ШУТИС-ийн хөдөлгөөн)	ШУТИС-ийн оюутнуудыг сайн дурын үйл ажиллагаанд идэвхтэй хамруулах	Клубын ахлагч, Хөдөлгөөн хариуцсан штафф	X/20
3.	КНЗ, Залуу экологич клубын санаачилсан мод тарих өдөрлөг	Мод тарих ач тус, ШУТИС-т өвлөгдөх үнэт зүйл бүтээх	КНЗ, Залуу экологич клуб	X/23
3.	Open mic зохион байгуулах (ШУТИС)	Хувь хүний чадварыг дээшлүүлэх, тайзны соёлд суралцах	Клубын ахлагч	X/27-ны өдрөөс 14 хоног бүр
4.	Инээдээр дархлаагаа дэмжье (Halloween)	Инээдээр дархлааг нь дэмжих хамрах хүрээ ШУТИС-ийн оюутнууд	Клубын ахлагч, Хамтарсан комедиан	X/29
5.	UB comedy open mic, Comedy LAB virgin mic	Клубын залуусаа мэргэжлийн тайзан дээр гаргах, чадвар суулгах	UB comedy, Comedy lab	X/25-ны өдрөөс хойш долоо хоног бүр

6.	Их сургуулиудтай хамтарсан тоглолт	Бусад сургуулиудтай туршлага судлах, өөрийн сургуулиа бусдад сурталчилах	Клубын ахлагч, бусад сургуулийн клубын ахлагч нар	XI/5
7.	“Student league” их сургуулиудын аварга шалгаруулах тэмцээн	Өөрийгөө хөгжүүлэх, Улсын аваргад сургуулиа төлөөлөн оролцох	Ub comedy, Оюутны холбоо	Тэмцээн зарлагдсан үеэр
8.	Student comedy club -тай хамтарсан хандивын тоглолт зохион байгуулах.	Бусдад туслах сэтгэлээр нэгдэх нь ямар ач холбогдолтойг таниулах	Клубын ахлагч нар	XII/1
9.	Улаан загалмай клубтай хамтарсан хандивын тоглолт.	Бусдад туслах сэтгэлээр нэгдэх нь ямар ач холбогдолтойг таниулах	Клубын ахлагч нар	XI/19
10.	“Шинэ жил ирлээ” Тайлан тоглолт.	ШУТИС-ийн оюутнуудын хаалтын тоглолт	Клубын ахлагч	XII/15

Хичээлийн намырын улиралд хийгдсэн ажилууд

Нэг.Манай клуб нь элсэлтэй авсанаас долоо хоногын дараа буюу 9 сарын 29нд UB COMEDY комедиан Баярааг урьж оролцуулж комедиан хүн гэж ямар хүн бэ? Хэрхэн комедиан болох гэх мэт суурь хичээлүүдийг танилцуулсан

/Зураг 1./



/Зураг 2./



Хоёр. Campus life оюутны хөгжилийн төвтэй хамтран comedy night зохион байгуулсан энэхүү тоглолтонд шинэ гишүүдээ оролцуулж анхны тайзан дээр гаргаж туршлага хуримтлуулсан.

/Зураг 3./



Гурав. Клубын гишүүдээ чанаржуулах зорилгоор 14 хоног тутамд нэг удаа open mic зохион байгуулж нийт ялсан тоогоор нь шилдэг гишүүнээр шалгаруулсан ба must comedy клубын гишүүн Г.Цолмонтөгс 3 удаа түрүүлж шилдэг гишүүн болсон.

/Зураг 4./



Дөрөв. UB comedy, Comedy Lab опэн микүүдэд тогтмол амжилттай оролцдог ба клубын ахлагч Г.Золжаргал түрүүлж Э.Сүрэнжав хоёрт орж байсан.

/Зураг 5./



Тав. Нийгмийн хариуцлагын хүрээнд MUST Comedy клуб нь 2019 оны 10 сарын 11-нд төрөөд зүрхний гурвалсан гажигтай гэж оншлогдон 2 сартай байхдаа яаралтайгаар амь аврах хагалгаа гэж Энэтхэг улсыг зорин хагалгаанд ороод ирсэн билээ. Одоо охины минь биеийн байдал тааруу болж байгаа учраас 2021 он 12 сард дахин Энэтхэг улсыг зорьж уушигны артерын даралт бөгөжлөх хагалгаанд орох шаардлагтай байгаа Биндэрьяа охинд зориулж хандивын тоглолт хийсэн.



Зургаа. Moffice comedy night-д must comedy клубын гишүүд урилгаар очиж тоглолтонд оролцсон.

/Зураг 6./



“СОЁМБО КЛУБ” –ИЙН ТАЙЛАН

Соёмбо клубийн “Танилцуулга хурал”

Соёмбо клубын шинэ элсэлт болон бүтцийн шинэчлэлт хийсэн. Клубийн ахлагч шинээр томилогдсон



Танд тусалъя аян

ШУТИС-ийн шинэ элсэгчдэд зориулсан танд тусалъя аян.



Шинэ элсэгч гишүүдийг идэвхижүүлэх “Дотоод үйл ажиллагаа”

Клубийн шинэ элсэгчдэд мэдээлэл олгох , чадавхжуулах хөтөлбөр сургалтууд.



Хотын соёл үйл ажиллагаа

ШУТИС-ийн оюутан залууст хотын соёл болон эерэг хандлагыг түгээх.

Зохион байгуулсан бүрэлдэхүүн

- Багийн бүрэлдэхүүн 14 гишүүн.

Үйл ажиллагааны үйл явц


- Сургуулийн хөл хөдөлгөөн ихтэй ШУТИС I-р байрны төв шат болон II-р байрны үүдээр зогсож оюутнуудад сургуулийн дүрэм журам, баруун гарын дүрмийг таниулан шаардлага тавьсан.









Хотын соёл үйл ажиллагааны график тайлан

Даваа гарагаас лхагва гарагийн хооронд хөл хөдөлгөөний тоо дунджаар хэр их байгааг графикаар үзүүлсэн байдал.





Дүгнэлт

2021 оны 10 сарын 11 ээс 2021 оны 10 сарын 15 хооронд зохион байгуулсан “Хотын соёл” үйл ажиллагаанд “Соёмбо” клуб хөл хөдөлгөөн ихтэй шат болон үүдээр шаардлага тавьж завсарлагаан тус бүр зогссон. Уг ажлыг гүйцэтгэх үед оюутнууд, сургуулийн багш ажилтнууд хөл хөдөлгөөн ихтэй шат болон үүдний тэмдэглэгээнд төдийлөн ач холбогдол өгдөггүй болох нь ажиглагдсан. Үүнээс үүдэн оюутнууд болон ажилчид бие биетэйгээ мөргөлдөх, бусдад төвөг учруулах тохиолдол их гарсан бөгөөд буруу шатаар өгсөх, буруу хаалгаар гарах нь хичээлээсээ хоцрох бүүр цаашлаад унаж бэртэх зэрэг зөрчил үүсгэдэг байна.

Хөл хөдөлгөөн 2021 оны 10 сарын 12 оос 2021 оны 10 сарын 14 өдрүүдэд баруун гарын дүрмээ баримталдаггүй болох нь “Хотын соёл” үйл ажиллагаагаар ажиглагдсан.

2021 оны 10 сарын 11-ээс 2021 оны 10 сарын 13 ны хооронд оюутнуудын зөрчил 10-15% тай байсан бөгөөд 2021 оны 10 сарын 16 гэхэд 5% болтлоо буурч үр дүн үзүүлсэн байна. Оюутнууд бидний тавьсан шаардлагыг эерэгээр хүлээн авч, зөрчилөө тухайн үедээ шууд засаж залруулж байсан.


“Оюутан эргүүл” үйл ажиллагаа

Үйл ажиллагаа


Соёмбо клуб нь 2021 оны 10-р сарын 11-ы даваа гарагаас 10-р сарын 16-ны баасан гараг хүртэл нийт 5-н өдрийн турш Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн “Т” байрны гаднах тамхины цэгт 7 гишүүний бүрэлдэхүүнтэй хяналт зохицуулалт хийсэн.

Үйл ажиллагааны зорилго

Сургуулийн ойр орчимд хараа хяналтгүй тамхи таталтыг багасгах зориулалтын тамхины цэгт тамхи татуулах шаардлага тавих зохицуулалт хийхэд мөн судалгаа шинжилгээ хийхэд энэ үйл ажиллагааны гол зорилго оршино



*17:54 цагийн байдлаар 6 орчим оюутан тамхи татаж байснаас
3 нь эмэгтэй оюутан байсан.*



*14:34 минутын байдлаар 20 гаран оюутан тамхи татаж байснаас
6 нь эмэгтэй оюутан байсан.*



Мягмар гараг



*2021.10.12 өдрийн 11:03 минутын байдлаар нийт 23 хүн байсан
бөгөөд үүнээс 22 эрэгтэй 1 эмэгтэй хүн байсан.*




12:37 минутын байдлаар ойролцоогоор 40 хүн байсан ба үүнээс 7 эмэгтэй үлдсэн хэсэг нь эрчүүд байсан.

Мөн II-р байрны ард байрлалд 3 хүн тамхи татаж байсныг шаардлага тавин тамхины цэг рүү нь явуулсан байгаа.



14:31 нийт 14 хүн байсан үүнээс 2 эмэгтэй оюутан бусад нь бүгд эрэгтэй оюутнууд байсан.



16:16 минутын байдлаар 51 хүн тамхи татаж байсан бөгөөд үүнээс 2 нь эмэгтэй хүн байсан.




Лхагва гараг



2021.10.13 өдрийн **12:38** минутын байдлаар 24 хүн тамхи татаж байсан бөгөөд 3 эмэгтэй оюутан байсан.



14:50 минутын байдлаар 31 хүн тамхи татж байснаас 7 нь эмэгтэй оюутан байсан.



16:15 минутын байдлаар 28 оюутан тамхи татаж байснаас
5 нь эмэгтэй оюутан байсан.



18:06 минутын байдлаар 18 оюутан тамхи татаж байснаас
2 нь эмэгтэй оюутан байсан

Мөн II-р байрны гадна 3 эмэгтэй оюутан тамхи татаж байсныг шаардлага тавин тамхины цэг рүү явуулсан.

Пүрэв гараг




2021.10.14 өдрийн 12:37 минутын байдлаар 26 оюутан тамхи татж байснаас 5 нь эмзэгтэй оюутан байсан.





14:32 минутын байдлаар 31 хүн тамхи татаж байсан бөгөөд бүгд эрэгтэй оюутан байсан.






Зориулалтын тамхины цэгээс өөр газруудад тамхи татаж байсан хүмүүст шаардлага тавин тамхины цэг рүү явуулсан.



16:14 минутын байдлаар 19 оюутан тамхи татаж байсан.
Үүнээс 2 нь эмэгтэй оюутан болон багш байсан.




Баасан гараг




2021.10.15 10:57 минутын байдлаар нийт 29 хүн байсан ба бүгд эрэгтэй оюутан байсан.

3 хүн тамхины бус цэгт татаж байсныг илрүүлж тамхины цэг рүү явуулсан.




12:39 минутын байдлаар давхардсан тоогоор нийт 39 хүн байснаас 3 эмэгтэй оюутан үлдсэн нь эрэгтэй оюутан байсан. 4 хүн тамхины цэг бус газар татаж байсныг илрүүлэн шаардлага тавин цэг рүү явуулсан.



14:36 минутын байдлаар 16 хүн тамхи татж байснаас 3 нь эмэгтэй оюутан байсан.

Мөн замын эсрэг талд тамхи татж байсан хүнд шаардлага тавин тамхины цэгрүү явуулсан.



16:15 минутын байдлаар 9 хүн тамхи татж байснаас 2 нь эмэгтэй оюутан байсан.



Тус тамхины цэгийн хяналт зохицуулалт судалгааны үр дүнд 2021 оны 10 дугаар сарын 11-ний Даваа гарагаас 10 дугаар сарын 15-ны Баасан гараг хүртэлх 5 хоногийн хугацаанд давтагдсан тоогоор ойролцоогоор 450 орчим оюутнууд тамхи татаж байгаа нь тогтоогдсон. Түүнээс давтагдсан тоогоор эмэгтэй оюутнуудын тоо ойролцоогоор 42 байсан.


5.3 Судалгаа

Тамхины цэгийн хяналт зохицуулалт болон мэдээлэл оюутнуудад хэр хүрдэг вэ? сэдвээр Соёмбо клуб нь БАС-ийн оюутны зөвлөлтэй хамтран судалгаа авсан бөгөөд нийт 400 гаруй оюутнууд идэвхитэй хамрагдсан байна.

- Нийт хамрагдсан оюутнуудын ихэнхи хувь нь БАС ийн оюутнууд байсан.



“Т” байрны гадаах тамхины цэгийг нийт оюутны 30,5% мэдэхгүй байна.



Мөн санал хүсэлт оюутнуудаас ирсэн бөгөөд тэрхүү санал хүсэлт нь сургуулийн ойр орчим тамхины цэгийг байхгүй байх нь зүйтэй гэж үзэж байгаа юм.



Ёрөн тамхины цэг энд бх ёстой юу? Хуулиндаа сургууль цэцэрлэгээс 500м радиус дотор иймэрхүү үйл ажиллагаа явуулах мөн хэрэглэхгүй байх тухай бдаг санадах юм эсвэл манай сургуулийн тамхичид хуулиас өөрсдийгөө дээр бодчихсон та нар өөгшүүлэгчид нь болж бгаага ойлгож бгаа бол болоодоо амжилт!

1 хариулт

Санал

2021 оны 10 сарын 7-ны өдөр 18:10 минутанд Ангийн дарга нарын хурал зохиогдсон бөгөөд уг хурал дээр мөн адил тамхины цэгийн асуудал түүнийг хэрхэн шийдвэрлэх тухай санал бодлоо дэвшүүлжээ. Үүнд:

1. ШУТИС-ийн Оюутнуудын тоо болон тамхины цэгт татах боломжтой хүний тоо буюу багтаамж
2. Тамхины цэгийн цаана байрлах агаарлах хэсэг буюу саад сандал руу ороход тамхи татаж байгаа хүмүүсийн хажуугаар заавал өнгөрч гарах шаардлагатай болж байгаа ба энэ асуудлыг шийдэх.
3. Тамхины цэгийн сааданд агааржуулагч нэмэх. Утааны үлдэц их сөрөг үр дагавар нэмэгдэнэ.
4. Сургуультай хэт ойрхон ба В давхарын цонх нээлттэй үед тамхины утаа орж ирдэг.

Дүгнэлт

2021 оны 10 дугаар сарын 11-ний Даваа гарагаас 10 дугаар сарын 15-ны Баасан гарагийн хооронд 5 хоногийн турш хэв журам сахиулах Соёмбо клуб ШУТИС-ийн хичээлийн "Т" байрны гаднах тамхины цэгт эрчимтэй хяналт зохицуулалт хийсэн. Тус хяналт зохицуулалтын үед тамхины утааны үлдэц ШУТИС-ийн хичээлийн II-р байрны анги танхимуудад орж байгаа, мөн тамхины цэг ШУТИС-ийн нийт оюутан залууст хүрэлцээ муутайн улмаас цар тахлын цаг үед хэт их бөөгнөрөл үүсгэх, сургуулийн ойр орчимд тамхидалт ихсэх, гудамж талбай бохирдох зэрэг маш олон асуудал үүсэж байгаагийн сацуу оюутнуудаас санал гомдол олноор ирсэн. Мөн дээр дурьдсан ангийн дарга нарын хурлын дэвшүүлсэн асуудал болон олон оюутнуудын санал гомдолын үндсэн дээр хэв журам сахиулах Соёмбо клубын зүгээс сургуулийн ойр орчимд тамхины цэг байх нь тохиромжгүй гэж дүгнэж байна.

6. Клубийн 80% гишүүд бомбер захиалан ижилссэн





“Ирээгүй ирээдүй” аян

Зорилго

Монгол улсын хэмжээнд тулгараад байгаа томоохон асуудлуудын нэг болох хүсээгүй жирэмслэлтийн эсрэг оюутан залуусын дуу хоолойг нэгтгэх, бэлгийн боловсролын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бие биенээ хайрлах, хүндлэх хандлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэхэд гол зорилго оршино.

Хамрах хүрээ

ШУТИС-ын нийт оюутан залуус

Үйл ажиллагаа

1. “Аз жаргалтай гэр бүл” гэрэл зургийн уралдаан /зохиомжит зураг/ 2021 оны 11-р сарын 8-15-ны өдрүүдэд бүтээлүүдийг хүлээн авч 11-р сарын 18-ны өдөр шагналт байруудыг шалгаруулна.
2. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон хөдөө орон нутгийн сургуулиудад “Мэтгэлзээн” тэмцээнийг 2021 оны 11-р сарын 12-ны өдөр зохион байгуулна.
3. Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын газраас оюутан залуучуудад бэлгийн боловсрол болон гэр бүл төлөвлөлтийн талаарх онлайн сургалт зохион байгуулна.

Хугацаа

2021 оны 11-р сарын 1-ны өдрөөс 2021 оны 11-р сарын 19-ны өдөр хүртэл үргэлжилнэ.

Ерөнхий зохион байгуулагч

ШУТИС-ийн “Соёмбо” клуб

Хамтран зохион байгуулагч

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР, ОСҮА, ЭМТ

Клубийн гишүүн “Ирээгүй ирээдүй” аянд зориулж постер болон лого зохион бүтээсэн.



Сошиал орчинд тавилттай бичлэг байршуулж хандалт авсан.



ШУТИС-ийн нийт оюутан залуусаас Хүсээгүй жирэмтлэл болон түүнээс урьдчилан сэргийлэх мэдлэг шалгах судалгаа авсан.



Ирээгүй ирээдүй аяны Инстаграм хаштаг бүхий постер байрлуулж Шутис-ийн багш ажилчид, оюутан залуусаар зураг татуулсан.



Аяны хүрээнд Гар зургийн уралдаан зохион байгуулсан.



Батлав: ОСҮА-ны дарга

Н. Самирбаатар

"Ирээгүй ирээдүй" аяны хүрээнд зохион байгуулж буй гар зургийн уралдааны удирдамж

Зорилго: Монгол улсын хэмжээнд тулгараад байгаа томоохон асуудлуудын нэг болох хүсээгүй жирэмслэлтийн эсрэг оюутан залуусын дуу хоолойг нэгтгэх, болгийн боловсролын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, бие биенээ хайрлах, хүндлэх хандлагыг нийтэд түгээн дэлгэрүүлэхэд гол зорилго оршино.

Хамрах хүрээ: ШУТИС-ийн нийт оюутан залуус

Шаардлага: -Төрөл хамаарахгүй

- АЗ-ийн хэмжээтэйгээр зурж ирүүлэх

-Аяны зорилго агуулсан байх

- Шинжлэх ухаан технологийн их сургуулийн бакалаврын түвшний I-IV

курсийн оюутан байх

- Хэтэрхий зохиосгүй талаас харуулахгүй байх

-Нэр, салбар сургууль, курс, оюутны код, утасны дугаараа тодорхой бичсэн байх

Хугацаа: 2021 оны 11 дүгээр сарын 8 – 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл бүтээлүүдийг хүлээн авна

Шалгаруулалт: 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр шалгаруулна.

Хүлээн авах газар: ШУТИС-ийн I-р байрны 3н давхарт "Соёмбо клуб"-ийн шилэн өрөө

Шагнал: I-р байр: Мөнгөн шагнал, өргөмжлөл

II-р байр: Мөнгөн шагнал, өргөмжлөл

III-р байр: Мөнгөн шагнал, өргөмжлөл

Зохион байгуулагч: ШУТИС-ийн Соёмбо клуб, ОСҮА.


Клубийн ахлагч

С.Бекболат

Ирээгүй ирээдүй аяны хаалтын үйл ажиллагаа



Хүсээгүй жирэмслэлт ба гэр бүл төлөвлөлт сэдвээр оюутнуудад цахим сургалт орсон.



Клубийн гишүүдээ идэвхижүүлэх бие бялдарт анхаарах үйл ажиллагаа








“Дулаан нар” аян

Алсмагдал дүүргийн эмзэг бүлгийн иргэдэд хандив цуглуулах, сэтгэлийн дэм өгөх аян.



Клубийн гишүүд аянд зориулж хандивын хайрцаг бүтээж байгаа.




Архины хэрэглээгүй залуус аяны хүрээнд зохион байгуулж буй лекц



Ёс зүйт, үлгэрлэгч оюутан бэлтгэх хөтөлбөр

Шутис-ийг төлөөлөн Соёмбо клубээс 5 оюутан оролцож, бэлтгэгч оюутан батламж авсан.



Save Munkhuu аян



“PATIAR” КЛУБИЙН ТАЙЛАН

КЛУБИЙН ТАНИЛЦУУЛГА

“Олон нийттэй харилцах ажил” мэргэжлийн 3, 4 дүгээр дамжааны төлөөлөл оюутнууд эвлэлдэн нэгдэж гэрэл зураг авах, гэрэл зурагтай ажиллах мэдлэг чадварыг сайжруулах гэх зэргээр онол практик хосолсон, гэрэл зураг сонирхогчдын “Patiar” клубийг санаачлан 2021 оны 5-р сард үүсгэн байгуулсан.

Patiar- Энэхүү нэрний утга санаа нь тэвчээр гэсэн үг юм.

Зорилго: Оюутнуудын гэрэл зургийн ур чадварын сайжруулах, програмууд дээр ажиллах, мөн практиктаа хэрэгжүүлэх, өсөж дэвшихэд өөрсдийн хувь нэмрээ оруулахад чиглэгдэнэ.

Зорилт:

- Оюутнуудад гэрэл зургийн талаарх үндсэн ойлголт, гэрэл зургийн ур чадвар, програмуудтай ажиллах ур чадваруудыг сайжруулан цаашид хөгжүүлэх;
- Гэрэл зургийн үзэсгэлэн, эвент үйл ажиллагаа болон сургалт зохион байгуулах;
- Тогтмол уулзалт зохион байгуулж, оюутан залуусын хамтын үйл ажиллагааг сайжруулах

Клубийн одоогийн хандалт: Нийт 200 дагагчтай.

The image shows a screenshot of a Facebook profile for 'Patiar'. On the left, there is a profile picture of a circular logo with the word 'PatiaR' in blue and yellow, overlaid on a film strip graphic. Above the profile picture, a notification says 'Patiar updated their profile picture.' with a timestamp of '4 Oct'. Below the profile picture, the text 'Гэрэл зураг сонирхогчдын клуб' is visible. On the right, the profile header shows 'Patiar' with a search icon and a settings gear. Below the header, there are tabs for 'Overview', 'Ads', 'Inbox', and 'Notifications'. A navigation bar includes 'Home', 'Groups', 'Jobs', 'Events', and 'Posts'. The main content area shows a message: 'Typically replies within a day' with a 'Send message' button. Below that, there is a question mark icon and a category 'Photography and videography'. At the bottom, the 'Community' section shows '196 people like this', '200 people follow this', and a list of friends who liked the profile, including 'Учралт Ням, Гэрэлт-Од Пүрэвдаваа and 68 other friends like this or have checked in'.

КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Клубийн гишүүдийн элсэлт: 10 сарын 18 наас онлайн байдлаар ШУТИС-ийн групп дээр зар оруулж элсэлтээ авсан. Одоогийн байдлаар нийт 51 оюутантай. Үүнээс идэвхтэй 20-25 оюутан байдаг.

Home Groups Jobs Events Posts Review

Patiar
4 Oct · 🌐

Өдрийн мэнд
Манай клубт элсэхийг хүсвэл доорх линкээр орж анкетаа бөглөөрэй. 😊
<https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeJGQE...> See more

ACCOUNTS.GOOGLE.COM
Google Forms - create and analyze surveys, for...


Odmaa Dangaasuren and 1 other

Like Comment Share

170 people reached > Boost Post

Patiar
18 Oct · 🌐

Сайн байцгаана уу?
💡 ШУТИС-ийн нийт оюутан залуусаа! 🤩
📷 Манай клуб элсэлтээ авахад бэлэн боллоо 🤩... See more



ШУТИС-т суралцаж буй оюутнуудын гэрэл зургийн ур чадваруудыг сайжруулах, програмууд дээр ажиллах, мөн практикт хэрэгжүүлж хөгжү... See more




23 Oct · 🌐


📣 ШУТИС-ийн "Patiar" Гэрэл зураг сонирхогчдын клуб 📷💡🤩
📷 ЭЛСЭЛТ-ээ авч дуусахад 2хон хоног үлдлээ
😊 Манай клуб Гэрэл зураг... See more



Гишүүдээ элсүүлсний дараа онлайн болон биечилсэн уулзалтыг зохион байгуулсан.



Баярын постер хийж гишүүддээ мэнд хүргэдэг.



Онол, практикийн сургалтууд зохион байгуулдаг.



Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулсан.

Сайн байцана уу? Оюутан залуусад:

ШУТИС-ийн "Patiar" Гэрэл зураг сонирхогчдын клубийн уулзалт 2021.11.02-ны өдөр ШУТИС-и... See more



Home Groups Jobs Events Posts

Patiar 15 Nov · 🌐

ГИШҮҮДИЙН АНХААРАЛД
"Оюутны намар 2021" Гэрэл зургийн үзэсгэлэнд бүтээлээ явуулаагүй гишүүд 11.17-с өмнө илгээнэ үү.
🔍Гишүү... See more

Хамрах хүрээ
"Patia" Гэрэл зураг сонирхогчдын клубийн нийт гишүүд

Үзэсгэлэнд ирүүлсэн бүтээлээс нийт хоёр бүтээл шалгаруулна. Шүүгчдийн бүрэлдэхүүнээр нэг Олон нийтийн таашаал хүртсэн нэг

Шалгарсан бүтээл тус бүр Өргөмжлөл, гарын бэлгээр урамшуулна.

Бүтээлийг илгээхдээ оролцогчийн овог, нэр, сургууль, мэргэжил, курс, холбогдох дугаар, бүтээлийн нэртэй байна.

"ОЮУТНЫ НАМАР 2021" ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

PatiaR

Бүтээлийг 2021 оны 11 сарын 05-17-ны өдрийн 18:00 цаг хүртэл Patiar2021@gmail.com хаягаар хүлээн авна.

Үзэсгэлэнд нийт 28 оюутны, 36 бүтээл ирсэн бөгөөд үүнд үзэгчдийн саналаар 1 бүтээл, шүүгчдийн саналаар 1 бүтээл тус бүрийг шалгаруулж, дурамж мөнгөн шагналаар шагнасан.

29 Nov · 📷

ГЭРЭЛ ЗУРАГ СОНИРХОГЧДЫН "PatiaR"
КЛУБИЙН
ҮЗЭСГЭЛЭНГИЙН ДҮН ГАРЛАА
2021 оны 11 сарын 22-29-ний өдөр гэрэл
зураг сонирхогч оюутнуудын "PatiaR"
клубээс... See more





#SAVE MUNKHUU

Бидний хайрт хүү Эрдэнэмөнх нь 21 настай. Ерөнхий боловсролын 48 ба 52-р сургуульд суралцаж төгссөн. ШУТИС-н Цахилгаан электроник инженер мэргэжлээр төгсөх курсийн оюутан.

2021 оны 10-р сарын 11-нд нарийн, шулуун гэдэсний хорт хавдартай элгэнд үсэрхийлсэн гэж оношлогдон эмчилгээ хийлгэж эхэлсэн. Химийн эхний шатны эмчилгээнд орсон бөгөөд цусны архаг дутмагшилтай, ялтас эсийн хэмжээ хэвийн хэмжээнээс өндөр байгаа нь цаашид эмчилгээнд орох боломжгүй байдалд ороод байна.

Турк улсын Acibadem Altunizade Hospital эмнэлгээс эмчлэгдэх боломжтой гэсэн хариу ирсэн ба яаралтай эмчилгээнд явах болсон тул ард түмнээсээ #SaveMunkhuu хандивын аянд нэгдэж хүүд минь амьдрал бэлэглэхийг та бүхнээсээ чин сэтгэлээсээ хүсэж байна.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай








Хандивын данс: Т.Аюушмаа/Ээж/ Хаан Банк 5405269944
Холбогдох утас: Ээж-88032769,95682568 Ах-99905021

Сайн дурын үйл ажиллагаанд үзэсгэлэнгээс үлдсэн гэрэл зургийг зохиогчийнх нь зөвшөөрөлтэй зарж хандивын үйл ажиллагаанд оролцож байна.

ЦААШИД ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Үйл ажиллагааг жигд идэвхтэй бүх гишүүдийг хамруулж сургалтаа орох
2. Өөрсдийн гэсэн жижиг студитэй болох
3. Багш нар, оюутны зөвлөл, бусад клубийн үйл ажиллагаанд хамтран ажиллах
4. Гишүүдийг богино хугацаанд чанаржуулах хөтөлбөр хэрэгжүүлэх
5. Сайн дурын үйл ажиллагааг санаачлан зохион байгуулах

“ХЯТАД ХЭЛ”-НИЙ КЛУБИЙН ТАЙЛАН

Хятад хэлний ярианы клубийн товч танилцуулга

Хятад хэлний клуб нь 2015 оны 10 сарын 1 нд байгуулагдсан, хамрах хүрээний тухайд ШУТИС-ийн нийт оюутныг хамарч үйл ажиллагаагаа явуулдаг сайн дурын клуб юм. Хятад хэлний болон мэргэжилтэн 1 багш, 295 гишүүнтэй энэ улирал үйл ажиллагаагаа зохион явуулсан.

Клубийн үйл ажиллагаа нь дараах зорилгуудын хүрээнд явуулж байна. Үүнд:


- ШУТИС-ийн хятад хэл сурч буй болон сонирхож буй оюутнуудыг дэмжих
- Хятад хэл, соёлыг түгээн дэлгэрүүлэх
- Хэлний бэрхшээлгүй чадварлаг боловсон хүчинг бэлтгэхэд туслах зорилготой.

2020-2021 оны хичээлийн жилийн клубийн ахлагчаар Гадаад хэлний сургуулийн 4-р курсийн оюутан Т.Одонцэцэг, клубийн зөвлөх багшаар Гадаад хэлний сургуулийн Ази судлалын тэнхимийн хятад хэлний багш Ц.Эрдэнэзаяа (Ph.D) нар ажиллаж байна.

Нийт идэвхитэй 295 гишүүнтэйгээс:

- 1-р курсийн 100 оюутан
- 2-р курсийн 60 оюутан
- 3-р курсийн 75 оюутан
- 4-р курсийн 60 оюутан тус тус бүртгэлтэй байдаг.

Гишүүнчлэлийн харьцаа




Зохион байгуулсан үйл ажиллагаа

Клубийн үйл ажиллагаа нь дараах чиглэлээр зохион байгуулагдлаа Үүнд:

1. Хятад хэлний клубийн “Танилцуулга хичээл”
2. Хичээлийн нэмэлт давтлага
3. Төгсөгчдийн цуврал лекц 1: “Ментортой болохуй”
4. Төгсөгчдийн цуврал лекц 2: “TUTOR хэлний чадвараа дээшлүүлэх”
5. “ШУТИС-ХЯТАДАД СУРАЛЦАГЧИД-2” Чуулга уулзалт
6. Хятад хэлний булан “健康在于运动”
7. Хятад хэлний булан “专业与工作”
8. “ОЮУТАН ЗАЛУУСЫН ХЭЛ ЯРИАНЫ СОЁЛ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД” СЭДЭВТ ЛЕКЦ

1. Танилцуулга хичээл, хичээлийн давтлага



50±оюутан


Төгсөгчдийн цуврал лекц 1: “Ментортой болохуй”

ШУТИС-ийн сайн дурын хятад хэлний клуб 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын арга хэмжээний хүрээнд “Төгсөгчдийн цуврал лекц”-ээ: “Ментортой болохуй” сэдвээр эхлүүллээ.

Сургуулийн чиглэл зорилгыг дэмжин 2+2 хөтөлбөрийн, техник технологийн орчуулагчийн болон хятад хэл суралцаж буй оюутнуудын харилцан бие биеэ дэмжиж, харилцан хөгжиж, багаар ажиллахад нь туслах зорилгоор Хойд хятадын эрчим хүчний их сургуулийн магистрант/СЭХ/ Б.Амгаланбазар, цахилгаан хангамж 2+2 хөтөлбөрийн IV ангийн оюутан Б.Цэлмэг, сэргээгдэх эрчим хүч 2+2 хөтөлбөрийн IV ангийн оюутан Б.Билгүүн нарыг урьж энэхүү лекцээ зохион явууллаа.




Клубийн маань зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа энэ улирлын хичээлийн зорилго, төлөвлөгөө болон тус лекцээр ярилцах сэдвийн хүрээнд мэдээллээ танилцуулж эхлүүлэв.



Уригдсан илтгэгч нар:

- Ментор гэж ямар хүн байх, ментортой болохын давуу тал.
- Дотоод, гадаадад суралцах тэтгэлэг, түүний төрөл, шалгуур үзүүлэлт.
- Тэтгэлгийн эсээ болон суралцах төлөвлөгөөгөө хэрхэн үр дүнтэй бичих, бүрдүүлэх, зөвлөмж.
- Цагийн менежмент.
- Ардын сургаалаар бие хүн болж төлөвших.
- Суралцахад цагаа зөв зохицуулж, бэрхшээлийг даван туулж, өөрийгөө ялж сурах гэх мэт олон чиглэлээр илтгэл лекцээ танилцуулан, оюутан дүү нартаа өөрсдийн хичээлийн файлаа хуваалцан, санаа сэдэл өгсөн тэднийг бүтээлчээр суралцах урам сэдэл, ухаарлыг төрүүлсэн үр өгөөжтэй лекц болж өндөрлөсөнд клубийн хамт олны зүгээс чин сэтгэлээсээ талархалтай байна.

Энэхүү лекцэд ГХС-ийн техник технологийн орчуулагчийн хятад хэлний 1,4-р ангийн оюутнууд, ЭХС-ийн цахилгаан хангамж, дулаан хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн 2+2 хөтөлбөрийн 1,2,3,4-р ангийн оюутнууд, ХШУС, ГУУС-ийн хөтөлбөрийн оюутнууд болон клубийн бусад идэвхтэн гишүүд нийт 70 орчим оюутнууд идэвхтэй оролцлоо.



2. Төгсөгчдийн цуврал лекц 2: “TUTOR хэлний чадвараа дээшлүүлэх”

ШУТИС-ийн сайн дурын “Хятад хэлний клуб” 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын “Төгсөгчдийн цуврал лекц 2”-оо 2+2 хөтөлбөр, техник технологийн орчуулагчийн ангийнхан болон хятад хэл суралцаж буй оюутнуудад зориулан “TUTOR хэлний чадвараа дээшлүүлэх” сэдвээр үргэлжлүүлэн зохион явууллаа.


Салбар яам болон сургуулийн зорилго, чиглэлийг дэмжин, цахим сүлжээний асар өргөн боломжийг боловсролын тэр дундаа хэл сурахад ашиглан оюутан өөрөө хөгжих, ур чадвараа нэмэгдүүлэн, бие дааж суралцахад нь туслах зорилгоор ТТО-хятад хэлний төгсөгч, Мон Тай Сино Групп orchuulga.mn-ийн хятад хэлний орчуулагч Э.Отгонбаяр, Хойд хятадын эрчим хүчний их сургуулийн цахилгаан хангамж 2+2 хөтөлбөрийн 4-р ангийн оюутан Н.Жаргал, сэргээгдэх эрчим хүч 2+2 хөтөлбөрийн 4-р ангийн оюутан Н.Улсболд нарыг урьж энэхүү лекцийг зохион байгууллаа.




Клубийн зөвлөх Ц.Эрдэнэзаяа багш маань үйл ажиллагаагаа танилцуулан, тус лекцээр ярилцах сэдвийг танилцуулж эхлүүлэв. Уригдсан илтгэгч нар:

- Хэл сурах зорилго, сууриа хэрхэн зөв тавих, өөрт тохирох арга барилаа олох
- Интернет ашиглах хэрхэн хэлний түвшингээ сайжруулах, түүний давуу болон сул тал
- Хятад, англи хэл сурахад туслах апп-ууд
- Хэлний дөрвөн чадвараа хэрхэн зэрэг дээшлүүлэх арга, туршлага
- Ханз цээжлэх түгээмэл арга
- Хэл сурахад: эх хэл-судалгаа-гадаад хэл-сэтгэлзүй эргэх холбоо хамаарал
- Орчуулагч хүний эзэмших чадвар гэх мэт өргөн хүрээнд ярилцлаа.

Тэр хэмжээгээрээ суралцагчаас “сурах” бэлтгэл, хариуцлага, зорилгоо ухамсарласан бүтээлч байх зэрэг хувийн зохион байгуулалт, чадвар, сахилга бат ихээхэн шаарддаг зэрэг талаар лекцээ өрнүүлэв.



Энэхүү лекцэд Гадаад хэлний сургуулийн техник технологийн орчуулагчийн хятад хэлний ангийнхан, Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн болон Эрчим хүчний сургуулийн сэргээгдэх эрчим хүч, цахилгаан хангамж, дулаан хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн 2+2 хөтөлбөрийн 1-4-р ангийн болон клубийн бусад идэвхтэн 60 гаруй гишүүн оюутан идэвхтэй оролцлоо.




“ШУТИС-ХЯТАДАД СУРАЛЦАГЧИД-2” Чуулга уулзалт

ГХС-ийн Ази судлалын салбараас 2021-2022 оны намрын улирлын арга хэмжээний хүрээнд ШУТИС-ийн үнэт зүйл “ШУТИС-ЛАГ БАЙЯ”, асуудлыг бүтээлчээр шийдвэрлэе” уриаг дэмжиж, оюутан залуусыг суралцагчаас бүтээгч болж өсөн дэвжихэд урам зориг өгөн, элсэгч-төгсөгч-ажил олгогчдын эргэх холбоог өргөжүүлэх, сургалт судалгааны хүрээнд харилцан туршлага солилцох зорилготой “ШУТИС-ХЯТАДАД СУРАЛЦАГЧИД-2” чуулга уулзалтыг google

meet платформоор 2021 оны 10 дугаар сарын 23-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

ШУТИС хятад хэлтэй мэргэжилтэн бэлтгээд 11 дэх жилтэйгээ золгож байгаад бөгөөд анх 2009 оноос ГХС Техникийн мэргэжлийн орчуулагч, 2011 оноос ГУУС Геодизи, 2012 оноос ЭХС ЦХ, ДХ, Биоинженерчлэл, 2016 оноос СЭХ, 2018 оноос ХШУС Химийн инженерчлэл, Үйлдвэрийн экологи, Математик статистик зэрэг мэргэжлээр хамтарсан хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж байна. Энэ хугацаанд нийтдээ 250 орчим бакалавр оюутан, 30 орчим магистр төгсөж, мэргэжлээрээ амжилттай ажиллаж байна.



- Чуулга уулзалтыг ГХС-ийн ЭНБД, дэд профессор, доктор (Ph.D) Н.Мэнд
- ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Цогзолмаа
- ГХС-ийн АСС-ийн эрхлэгч, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа нар нээн үг хэлж, илтгэлээр эхлүүллээ.

Чуулга уулзалтын үндсэн илтгэл:

- М.Долгоржав (ГХС-ийн ТМО-хятад хэл мэргэжлийн төгсөгч, БНХАУ, Шаньдун их сургуулийн магистр, "МОНОС Фарм трейд" ХХК-ийн гадаад харилцааны албаны ахлах менежер)

“Хүйтэн дайны дараах үеийн хятад, монголын эдийн засаг, гадаад худалдааны харилцаа”

后冷战时期的中蒙经贸关系的研究

- Э.Энхтүшиг (БНХАУ, ХХЭХИС-ийн 2+2 ЦХ мэргэжлийн төгсөгч, магистрант, “Energy international LLC” Реле хамгаалалтын инженер)

“Хийн тусгаарлагатай хуваарилах байгууламжийн нийтлэг гэмтлийн загвар дахь бяцхан цахилалтын хэт өндөр давтамжийн аргын онцлогийн судалгаа”

0GIS典型缺陷模型局部放电UHF特征研究

- Г.Мөнхнасан (БНХАУ, ХХЭХИС-ийн 2+2 СЭХ мэргэжлийн төгсөгч, Грийн Солар Энержи ХХК, инженер)

"Перовскитийн материалын А сайтийн бүтцийн өөрчлөлтийн квантын динамик симуляцийн судалгаа"

位基团掺杂钙钛矿材料结构变化的量子动力学模拟研究

- Ч.Сансар (БНХАУ, ХХЭХИС-ийн 2+2 СЭХ мэргэжлийн төгсөгч, "Innovtech Individual" ХХК-ийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал)

"Монгол дахь энерги хуримтлуулах технологийн өнөөгийн нөхцөл байдал ба цаашдын ирээдүй"

蒙古储能技术的现状及其应用前景

- У.Гэрэлмаа (БНХАУ, ХХЭХИС-ийн 2+2 ДХ төгсөгч)




"Хятад улсын эрчим хүчний нүүрсний шаталтын шинж чанарын судалгаа"




中国动力煤燃烧特性初步研究

- Т.Баасансүрэн (ГХС-ийн ТМО-Хятад хэл мэргэжлийн төгсөгч, "Оргил турбин инженеринг" ХХК, хүний нөөцийн менежер, ХАБЭА-н инженер)


Монгол, хятад хүний ургийн нэрийн бүтэц, утгыг харьцуулах нь

蒙汉人姓名对比研究 зэрэг сэдвээр үе үеийн хятад хэлээр төгсөгч нар оролцон, онол судалгаан дээр тулгуурлан хувь хүний туршлагаа хуваалцсан бодит, шинэлэг илтгэлүүд хэлэлцүүлээ.






Уг чуулга уулзалтад үе үеийн төгсөгч, суралцагч нар ГХС-ийн Техник технологийн орчуулга, ГУУС-ийн Шаньдун ШУТИС-тай геофизи, ЭХС-ийн ХХЭХИС-тай цахилгаан хангамж, дулаан хангамж, сэргээгдэх эрчим хүч, биоинженерчлэл, ХШУС-ийн ӨМАҮИС-тай химийн инженерчлэл, Наньжин АҮИС-тай үйлдвэрийн экологи, БХПИС-тай математик статистик 2+2 хамтарсан хөтөлбөрийн нийт 80 гаруй оюутан залуус, эрдэмтэн багш нар оролцлоо.



3. Хятад хэлний булан


ШУТИС-ийн сайн дурын хятад хэлний клуб “Chinese corner” буюу “Хятад хэлний ярианы булан” хичээлээ 1.“健康在于运动” 2.“专业与工作”зэрэг өдөр тутмын ахуй амьдрал, ажил мэргэжилтэй холбоотой чөлөөт сэдвээр санал бодлоо чөлөөтэй илэрхийлдэг болгох зорилгоор Күнзийн институтийн хятад хэлний мэргэжилтэн 路乘俊/Lu Cheng Jun/ багшийг урин google meet платформоор зохион явууллаа.



Дээрх сэдвийн хүрээнд 路乘俊 багш маань цаг үе, нөхцөл байдалд тохируулан Covid-19 холбоотой үг хэллэг, хэрэглээ, хэрхэн сэргийлэх гэх мэт мэдээллийг хятад хэлээр хэрхэн бичиж, ярьж хэрэглэхийг хичээлд хамрагдаж байгаа оюутан залууст заан зөвлөж, хоорондоо санал бодлоо солилцож, асуултад хариулж, үзэл бодлоо хуваалцаж, нэг нэгнийхээ мэдэхгүй зүйлийг зааж өгөн харилцан суралцав. Клубийн зүгээс оюутан залуусын хятад хэлээ сэргээж, сонсгол болон яриагаа сайжруулахад тус дэм болсон гэдэгт итгэлтэй байна.

“ОЮУТАН ЗАЛУУСЫН ХЭЛ ЯРИАНЫ СОЁЛ ХЭРЭГЛЭЭНИЙ АСУУДАЛД” СЭДЭВТ ЛЕКЦ

“Оюутан залуусын хэл ярианы соёл хэрэглээний асуудалд” сэдэвт лекцийг “суралцахуйд суралцахуй”-д буй оюутан залуусын эх хэлний боловсрол, хэл ярианы соёлыг таниулах зорилгоор клубийн зөвлөх Ц.Эрдэнэзаяа багшаа урьж энэхүү зохион явууллаа.




Клубийн зөвлөх Ц.Эрдэнэзаяа багш маань клубийн зорилго, үйл ажиллагааны үр дүн хийгээд шинэ зууны хүн байх, оюутан байх, хувь хүнээс бие хүн болж төлөвших, чадварлаг боловсон хүчин болох талаар оюутан залуустай ярилцаж лекцээ эхлүүллээ. Тус лекцээрээ ШУТИС-ийн 250 оюутнаас өдөр тутмын харилцаандаа ашиглаж буй мэндлэх, хүндлэх, талархах үг хэллэгийн судалгаа авч оюутан залуусын хэл ярианы соёл, хэрэглээг тодруулах,

-Судалгаанаас үзвэл оюутан залуусын мэндлэх, хүндлэх, талархах үг хэллэгт харь болон этгээд гажуу үг хэрэглэгдэхээс гадна монгол хэлнийхээ үгийг буруу хазгай дуудан хэрэглээндээ хэвшүүлж байгаа

-Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл найруулга, тайз дэлгэцийн бүтээлийн орчуулгын найруулга, монгол уламжлал, ёс заншлаа өвлүүлэх, мэдүүлэх явдал учир дутагдалтай байгаа

-Үүнээс бид өнө эртнээс ёс журмыг хичээнгүйлэн эрхэмлэж, мэндлэх, хүндлэх, талархах нь хүний эрхэм соёл болохыг үр хүүхдэдээ нялх балчраас нь эхлэн зааж сургаж ирсэн өвөг дээдсийнхээ сайхан уламжлалыг чанд баримталж оюутан залууст хэл, соёлын зөв хэрэглээг хэвшүүлэхийн чухлыг мэдүүлсэн ач холбогдолтой лекц болж өндөрлөлөө.



Үр дүн, дүгнэлт

2021-2022 оны хичээлийн жилийн намрын улиралд “Сайн дурын хятад хэлний клуб” жилээс жилд зохион байгуулж буй үйл ажиллагаагаа чанаржуулан илүү өргөн хүрээг хамарч сурж мэдсэн зүйлээрээ амжилт гаргах өөрийгөө нээх зэрэг олон талт хамтарсан үйл ажиллагаа зохион байгуулж байгаа билээ.

1. ШУТИС-ийн ГХС-ийн Ази судлалын салбарын хятад хэлний багаас дотоодын хамтын ажиллагаа, “Хятад хэлний олимпиад” арга хэмжээний хүрээнд Постер илтгэлийн тэмцээнийг МУБИС-ийн НХУС-ийн Дорно дахины хэл, арга зүйн тэнхимтэй хамтран 2021.11.01-2021.11.18-ны хооронд анхан болон дунд 2 үе шаттайгаар цахим хэлбэрээр амжилттай зохион явуулсан юм. Уг тэмцээнд ШУТИС-ээс нийт 25-н оюутан оролцож, ШУТИС-ГХС-4-р дамжааны оюутан З.Хулан тэргүүн байр. Хятад хэлний клубийн ахлагч ЭТТА-2р дамжааны оюутан Б.Оюундарь амжилттай оролцон “Тусгай байр”.

ШУТИС.ЭХС-2 дамжааны оюутан Э.Хулан “Шилдэг оролцогч” гэсэн амжилтуудыг үзүүлсэн юм.

2. Мөн Монгол-Орос найрамдал хамтын ажиллагааны хүрээнд ХХШ салбараас зохион байгуулсан “Всемирный Пушкин” шүлгийн уралдаанд клубын гишүүн ШУТИС.ЭХС-2 дамжааны оюутан Э.Хулан амжилттай оролцон 2-р байр эзэлсэн. Мөн клубийн гишүүн Ө.Мөнхзалгамж амжилттай оролцов.
3. Мөн Монгол-Орос найрамдал хамтын ажиллагааны хүрээнд ХХШ салбараас зохион байгуулсан “Моя родина Монголия” сэдэвт постер илтгэлийн уралдаанд
ЭТТА 2+2-2р дамжааны оюутан Б.Оюундарь, СЭХ 2+2-2р дамжааны оюутан С.Цэнгүүн нар амжилттай оролцсон юм.
 - Энэ бүгдээс зохион байгуулсан үйл ажиллагаагаа дүгнэж үзэхэд клубийн гишүүдийн үзүүлсэн амжилт, ахиц маш их үр дүнтэй . Цаашлаад энэ амжилтаа улам ахиулах
 - Санаачлан зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, хамруулсан оюутны тоо зэрэг сургуульдаа хувь нэмрээ орууллаа. Мөн түүнийгээ улам өргөжүүлэх
 - Манай клубийн хамгийн гол баримтлах зарчим бол клубийн гишүүдийг чадваржуулах, хувь хүний хөгжил, дотоод/soft skill/ ур чадвар мөн суралцахуйд суралцахуйг дэмжин ажиллах, үүнийгээ улам өргөжүүлж, сайжруулах юм.
 - Энэ бүгдээс бид төлөвлөсөн ажлаа 100%-тай биелүүллээ гэж үзэж байна.

“ЗАЛУУЧУУДЫН УЛААН ЗАГАЛМАЙ” КЛУБИЙН ТАЙЛАН

ЗАЛУУЧУУДЫН УЛААН ЗАГАЛМАЙ КЛУБИЙН ЗОРИЛГО:

ШУТИС-ийн оюутан, залуучуудын хүмүүнлэгийн үйлсэд, уриалан оролцуулж, хүнлэг энэрэнгүй үзэл санааг төлөвшүүлж, тэдний оролцоонд тулгуурлан хувь нэмэр оруулахад оршино.

БИДНИЙ УРИА:

ХҮМҮҮНЛЭГ ИРГЭН- ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Эрүүл мэндийг дэмжих, анхны тусламж үзүүлэх, гамшгиний бэлэн байдал хангах, нийгмийн оролцоог дэмжих, сайн дурын үйл ажиллагаанд оюутан залуусаа хамруулах

ҮНДСЭН ДОЛООН ЗАРЧИМ:

- Энэрэнгүй байх
- Шударга байх
- Төвийг сахих
- Бие даах
- Сайн дурын байх
- Нэгдмэл байх
- Түгээмэл байх

КЛУБИЙН ТАНИЛЦУУЛГА

2018 оны 10 сарын 06нд албан ёсоор Ш.Замлин 15 гишүүнтэйгээр үүсгэн байгуулсан.

2019-2020 он Ц.Намуундаръяа 15 гишүүнтэйгээр ахлан ажилсан.

2021 он:

Тэргүүн: С.Мичидмаа


Дэд тэргүүн: Д.Өгэдэй

Нарийн бичиг: Д. Амгаланцэцэг

Клубийн нийт гишүүд: 33

2021-2022 оны намрын хичээлийн жил 30 гишүүн элсэн орсон. 1-2 курс.

Шинэ гишүүддээ клубийн үйл ажиллагаа, чиглэл, зорилго, зорилтын талаар TEAMS –ээр хурал зохион байгуулав.



ТАНИЛЦАХ АЯЛАЛ

ГИШҮҮДИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ



БҮЖГИЙН ХИЧЭЭЛ

ГИШҮҮДИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ

УУЛЫН АЛХАЛТ



МУЗН-ИЙН ТАНИЛЦАХ СУРГАЛТ



ЦУСНЫ ДОНОРЫН ӨДӨРЛӨГ

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

ШУТИС-ийн ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

ОЮУТНЫ ХОЛБОО- той хамтран ажилласан. 120 гаруй багш ажилчид, оюутан залуус цусаа бэлэглэсэн.

11 сарын 19нд 9-13 цагийн хооронд зохион байгуулагдсан.



Give Blood

Give Life

ХЭЭЭЭ: 2021 оны 11 сарын 19-ний өдөр 09:00-13:30 цагийн хооронд
ХААНА: Хичээлийн I-р байрны 3 давхарт Хурлын заалны задгай талбай




ЦҮС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
ШУТИС-ийн ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ
ОЮУТНЫ СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБА
ЗАЛУУЧУУДЫН УЛААН ЗАГАЛМАЙН КЛУБ

ХАНДИВИЙН ТОГЛОЛТ



MUST COMEDY клубтэй хамтран зохион байгуулсан.
2021.11.24 нд Молуушийг газар зохион байгуулагдсан.
Урилгаар Комедиан Баяраа, Жак хүрэлцэн ирсэн.

СЭТГЭЛ ЗҮЙГЭЭ ОЙЛГОХ НЬ СУРГАЛТ



БИ МЭРГЭЖИЛТЭН УРАЛДААН

ЗОРИЛГО:

ШУТИС-ийн Залуучуудын Улаан Загалмай клубээс зохион байгуулж буй уралдаан нь оюутан залуучуудыг сурч буй мэргэжилдээ дуртай болох, өөрийгөө илэрхийлэх, ирээдүйн мэргэжил сонголтоо хийх гэж буй дүү нартаа сургууль болон мэргэжлээ танилцуулж зөв сонгоход нь туслах, идэвх оролцоог дэмжихэд уралдааны зорилго оршино.



САНТА АЯН



ЗОРИЛГО:

Хүүхэд залуусыг хүмүүнлэгийн үйлсэд татан оролцуулснаар хүнлэг энэрэнгүй үзэл төлөвшүүлэх, шинэ жилийн баярыг угтан өрх толгойлсон, олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, зорилтот бүлгийн, улсын халамж, тэтгэвэрээс ангид өрхийн хүүхэд багачуудад бэлэг өгч баярлуулах.

ХУГАЦАА: 2021.12.07-2021.12.1

11. СУДАЛГАА


1. Их сургуульд ороод танд ямар сэтгэгдэл төрсөн бэ?

23 responses




Нас

22 responses



3. Ямар асуудлаас үүдэн сэтгэл зүйн өөрчлөлтөнд орсон бэ?

23 responses



ХАНДИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ДҮГНЭЛТ

Залуучуудын улаан загалмайн клуб нь энэ 2021 оны намрын улиралд 12-н ажил зохион байгуулахаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 10-н ажил зохион байгуулагдаж 9-н ажил амжилттай зохион байгуулагдсан.

Цаашид анхаарах зүйлсд гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлж идэвхжүүлэх, үйл ажиллагааг улирлын эхний долоо хоногт төлөвлөх шаардлагатай. Ингэснээр гишүүд тодорхой хугацаанд зохион байгуулалтад орж бэлтгэл ажил сайн хангах, төлөвлөгөөт бус ажил нэмэгдэхэд ажлын гүйцэтгэлд нөлөөлөхгүй байх давуу тал бүрдэхээр байна.

Сургуулийн зүгээс гишүүдийн хурал зохион байгуулах, сургалтын үйл ажиллагаанд зориулж анги танхим гаргаж өгөх зэргээр дэмжлэг үзүүлэх хэрэгцээтэй хэвээр байна.

ШУТИС-ИЙН УРЛАГИЙН КЛУБҮҮДИЙН ТАЙЛАН

“ХОС УЯНГА ЦЭНГЭЭНТ БҮЖГИЙН” КЛУБИЙН ТАЙЛАН

Товч танилцуулга

Зорилго: ШУТИС-ийн оюутнуудын чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх, бие бялдарын зөв хөгжлийг олгоход оршино.

Үйл ажиллагааны чиглэл:

Манай клуб нь анх 2003 оноос үйл ажиллагаагаа эхлэн тасралтгүй явуулсаар байгаа билээ. Бид оюутнуудын чөлөөт цагийг зөв боловсон үр бүтээлтэй өнгөрүүлэхэд анхааран бүжгийн урлагт дуртай хүн бүхэнд нээлттэй байдаг ба семистер болгон 4-5 минутын бүжгийг элсэн орж ирж буй гишүүддээ зааж бүжгийн техник болон бие бялдарын зөв дадал хэвшилийг бий болгоход чиглэнэ.

Хийж гүйцэтгэсэн ажил

- Клубийн дотоод үйл ажиллагаа
- Клубын гаднах үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагааны идэвхи оролцоо. Клубийн дотоод үйл ажиллагаа

Клубийн дотоод үйл ажиллагаа

Клубын үйл ажиллагаа буюу бэлтгэл маань энэ улиралд 2021 оны 10-р сарын 25 эхлэн 9н 7 хоногийн турш явагдаж шинэ гишүүддээ “Латин” төрлийн бүжгээ амжилттай зааж бусад бүжгийн техник болон биеийн сунгалт, дасгал хөдөлгөөнийг чанартай хийлгэн чадварыг нэмэгдүүлсэн. Идэвхтэй дасгал хөдөлгөөн хийснээр энэ цар тахлын хүнд хэцүү үед дархлаа тогтож илүү эрүүл чийрэг байхад тусалсан ба манай гишүүдээс ямарваа нэгэн өвчин илрэлгүй энэ улирлыг дуусгасандаа илүү бахархуштай зүйл нь болсон билээ.

I - 327 тоот “Оюутны бэлтгэл”-ийн танхимд хичээллэх клубүүдийн цагийн хуваарь.
2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирал
(2021 оны 09 сарын 27- 12 сарын 10 хүртэл)

Гараг Хуваарь	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
3-р пар 11:00-12:30		Ардын бүжгийн клуб	Чөлөөт бүжгийн клуб	Морин хуур клуб	Морин хуур клуб	Хөтлөгчийн клуб
4-р пар 13:00-14:30	Дуулаач клуб	Ардын бүжгийн клуб	Чөлөөт бүжгийн клуб	Морин хуур клуб	Морин хуур клуб	MUST COMEDY
5-р пар 14:40 – 16:10	Дуулаач клуб	Чөлөөт бүжгийн клуб	A- Capella хамтлаг	Хөтлөгчийн клуб	Ардын бүжгийн клуб	Морин хуур клуб
6-р пар 16:20 – 17:50	Хос-Уянга хамтлаг	Чөлөөт бүжгийн клуб	Дуулаач клуб	Хөтлөгчийн клуб	Ардын бүжгийн клуб	Хос уянга хамтлаг
7-8-р пар 18:00 – 21:00	Хос-Уянга хамтлаг	Хос-Уянга хамтлаг	MUST COMEDY	Хос-Уянга хамтлаг	Мэргэн шагайн харваа клуб	

Зураг1. Хос Уянга клубын бэлтгэлийн хуваарь

Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагаа болон сайн дурын үйл ажиллагааны идэвхи оролцоо.

- 2021 оны 11-р сарын 25ны өдөр Монгол улсын орчин цагийн боловсрол шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 100 жилийг тохиолдуулан ШУТИС-ийн профессор, багш ажилчдад шагнал гардуулах хүндэтгэлийн ёслолд мэндчилгээ үзүүлэв. /Зураг 2,3/
- Бидний анд нөхөр, ах дүү, аав ээжийн хайртай хүү Эрдэнэмөнх маань хүн болгонд тохиолдоод байдаггүй хүнд өвчин болох нарийн гэдэсний хорт хавдартай гэж оношлогдсон ба уг өвчин Турк улсад эмчлэгдэх боломжтой. Үүнтэй холбогдолтой [#savemunkhuu](https://www.instagram.com/savemunkhuu) хандивын аян эхэлсэн. Уг аяны хүрээнд ШУТИС Оюутны холбоо болон салбар сургууль бүрийн Оюутны зөвлөлийн санаачилгаар 2021 оны 12-р сарын 9-ны өдөр хандивын тоглолтыг зохион байгуулсан. Найздаа амьдрал бэлэглэхээр бид бас нэгдсэн. /Зураг 4./



Зураг 4.

Дүгнэлт

Бидний энэ семестерийн үйл ажиллагаа маань амжилттай болж дууслаа. Нийт энэ семестерийн зохион байгуулсан, оролцсон үйл ажиллагаануудаа дүгнэхэд зарим зүйл дээр дутмаг зүйл байгаа хэдийч өмнөх улиралуудтайгаа харьцуулахад шинэ санаа, санаачлага ихтэйгээс гадна клубийн дотоод уур амьсгал, хийсэн бүтээсэн зүйл ихтэй байв. Ирэх хаврын улиралд хийж буй үйл ажиллагаануудынхаа чанар дээр анхаарч, өмнө алдсан зүйлс дээрээ үнэлэлт дүгнэлт хийж шийдэлд хүрч илүү амжилттай ажиллах болно.

“МОРИН ХУУР”-ЫН КЛУБИЙН ТАЙЛАН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- Байгуулагдсан огноо: 2017.02.14
- Хамрах хүрээ: ШУТИС-д суралцдаг бүх оюутнууд
- Удирдсан багш: Цэрэндоржийн Болдбаатар
- Гишүүд: 5 эрэгтэй

КЛУБИЙН ЗОРИЛГО

Морин хуурын клуб нь хөгжим тоглох сонирхолтой оюутнуудад нээлттэй бөгөөд хөгжмийн суурь мэдлэг, тайзны соёл зэрэгийг зааж өгөх юм. Мөн тайзан дээр тоглон өөрийгөө нээн хөгжүүлэх боломжийг олгодог билээ.

ЧИГЛЭЛ

Морин хуурын хөгжимчдын тулгамддаг асуудал болох тайзны сандрал, биеэ авч явах байдал, хөгжмийн аяыг мэдэрч тоглох, өөртөө итгэлтэй байдлыг клубийн ахлагч болон чадварлаг багшийн тусламжтай хөгжүүдэхэд чиглэсэн.

ОРОЛЦСОН АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Клубын ахлагч Б.Мөнх-Очир “Монголын шинжлэх ухааны академийн 100 жилийн ойн хүрээнд” зохион байгуулагдсан Эрдэм шинжилгээний хурлын нээлтэд морин хуур тоглосон. Мөн ШУТИС-н төв байрны шинэчилсэн спорт заалны нээлтэнд ШУТИС-н ХШУС-ийн эрдэм шинжилгээний олон улсын хурлын нээлтэнд морин хуур тоглосон юм.



Зураг 1.



Монголын багш нарын баярын шагнал гардуулах ёслолын нээлтэнд клубын гишүүд морин хуур тоглосон.

КЛУБИЙН ГИШҮҮДИЙН ҮР ДҮН

- Манай клубын гишүүн Д.Сүх-Эрдэнэ “ЭХС-Урлагийн бага наадам”-д гуравдугаар байр
- Манай клубын гишүүн Э.Энх-Амгалан “МХТС-Урлагийн бага наадам”-д амжилттай оролцсон
- Клубын цагуудад ирж хөгжмөө давтсанаар тэдгээрийн ур чадвар мэдэгдэхүйц сайжирсан юм. Мөн сургуулийн үйл ажиллагаануудын нээлтүүдэд морин хуур тоглож тайзны соёл сурсан билээ.
- Морин хуур хөгжмийн талаарх мэдлэг сайжирч, өөртөө итгэлтэй болсон

ДҮГНЭЛТ

Морин хуурын клуб энэ семистэр үйл ажиллагаагаа идэвхжүүлсний үр дүнд клубын гишүүд нэмэгдэж сургуулийн арга хэмжээнд идэвхтэй оролцож байна. Мөн гишүүд хамтдаа бэлтгэлийн өрөөнд цагийг үр дүнтэй өнгөрөөн найзууд болсон нь цаашдын үйл ажиллагаанд бүр сайн оролцох юм. Харин клубын дотоодын үйл ажиллагаа цөөхөн байсан. Ийнхүү ирэх семистэрд алдаа дутагдалдаа анхаарч ажиллах болно.

“ДУУЛААЧ”-ИЙН КЛУБИЙН ТАЙЛАН

Зорилго

Дуулаачийн клуб нь чадварлаг багшийн удирдлаганд элсэн орсон оюутнуудын дан ганц дуулах авьяасыг хөгжүүлэхээс гадна өөрийгөө бусдад илэрхийлэх биеэ зөв авч явах цаашлаад алдартай дуучин болох замыг нь нээж өгөх юм.

Үйл ажиллагааны чиглэл


Дуулаачийн клуб нь хувь хүн дотоод сэтгэлдээ мэдэрч байгаа зүйлээ дуу хойлоо болон хөгжмөөр дамжуулан түүнийгээ илэрхийлэхэд багшийн зөвлөгөө тусламжтайгаар бусдад хүргэхэд чиглэнэ. Мөн урлагаар дамжуулан гоо зүйн мэдрэмж дээшлүүлэх болон ёс зүйтээ зөв боловсон болгоход чиглэдэг.

Товч танилцуулга

- ▶ Байгуулсан огноо: 2011 онд
- ▶ Хамрах хүрээ: ШУТИС-ийн бүх оюутнууд
- ▶ Багш: Цэрэндоржийн Болдбаатар
- ▶ Гишүүнчлэл 14 – 6 эмэгтэй, 8 эрэгтэй

■ Эмэгтэй оюутнууд

■ Эрэгтэй оюутнууд



Чадваржуулах сургалтад клубээ төлөөлж гишүүн Я.Сэрээтэр оролцсон.



2021.11.11 Семистэрийн хичээлийн сүүлийн өдөр

Клубийн 14 гишүүдээс 6 хүн болон багш.



2021.12.08



Клубүүдийн нэгдсэн үйл ажиллагааны болон сайн дурын үйл ажиллагааны оролцоо идэвх

- Соёмбо клубийн зохион байгуулсан “Ирээгүй ирээдүй” гар зургийн уралдааны хаалтын үйл ажиллагаанд манай дуулаачийн клубийн “3 охин хамтлаг” “Аавдаа баярлалаа” дууг дуулсан.



2021.11.19

Монгол Улсад орчин цагийн боловсрол, шинжлэх ухааны байгууллага үүсч хөгжсөний 100 жил, дэлхийн багш нарын 27, Монголын багш нарын 55 дахь өдрийг тохиолдуулан ШУТИС-ийн профессор багш, ажилчидад шагнал гардуулах ёслолын ажиллагаанд оролцсон зурагнууд.

- ШУТИС-ийн профессор багш, ажилчидад шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Анхсор, Хариун, Сэрээтэр нар “Аавдаа баярлалаа”.



2021.11.25

- Багш нарын баярын шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Алтан-Оргил “Санах тусмаа дуулаарай”



2021.11.25

- Багш нарын баярын шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Анхсор, Алтан-Оргил, Халиун, Тулгат нар "ШУТИС Бидний бахархал" дууг дуулсан.



Үр дүн

- ▶ Манай клубын Анхсор БАС ХХ баг наадамд гоцлол дууны төрөлд Дэд байр эзэлсэн.
- ▶ Урлагийн бүх үйл ажиллагаанд манай клубын гишүүд оролцдог.
- ▶ Хоолойны дасгал уншсанаар уушигны багтаамж тэлсэн. Бас зөв техникээр дуулж сурсан.
- ▶ Хүн тус бүр 1 болон түүнээс дээш дууны панаграммтай болсон.
- ▶ Номын нээлт, заалны нээлт, соёмбо клубийн зохион байгуулсан "Ирээгүй ирээдүй" гар зургийн уралдааны хаалтын үйл ажиллагаанд багш нарын баярын хурал г.м ү/а-д тус тус оролцсон билээ.
- ▶ Үйл ажиллагаануудад орсоноор тайзны соёлд суралцсан.

Дүгнэлт

Ийнхүү манай клубийн бүхий л үйл ажиллагаа оюутны хөгжилд чиглэгдэж сургуулийн олон үйл ажиллагаанд оролцох цаашлаад хувийн амжилтанд болон ёс зүйд нь эерэгээр нөлөөлж байна. Мөн гишүүдийн амжилтаас үзэхэд энэ хичээлийн жилд амжилттай үйл ажиллагаагаа явууллаа. Нөгөө талаас дотоодын үйл ажиллагаа зохиож ажилласан үйл ажиллагаа цөөхөн байжээ. Иймээс дараа хичээлийн жилд дутагдалтай зүйлсээ засаж илүү хичээж ажиллах болно.